

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ  
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ  
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: АХГ-2021/03/-ЦАА-СА

2021 он

**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН**

Тайлан бэлтгэсэн:

**Монгол Улсын Ерөнхий  
аудиторын орлогчийн  
албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч, тэргүүлэх  
аудитор:**

Ц.Наранчимэг

**Аудитын дөрөвдүгээр  
газрын захирал,  
тэргүүлэх аудитор:**

Я.Самбууням

**Аудитын менежер:**

Д.Энхдалай

С.Нацагдорж

**Ахлах аудитор:**

П.Чанцалдулам

Б.Сэржмядаг

Б.Нарангэрэл

Б.Эрдэнэзул

**Аудитор:**

П.Амарсанаа

О.Баярмаа

Д.Болор-Эрдэнэ

Ч.Дашдаваа

Б.Долгоржав

М.Лхагвасүрэн

Ц.Мөнхтуяа

Л.Мөнхцацрал

Н.Нямсүрэн

С.Отгонхорлоо

Э.Энхбаатар

Ц.Энхжаргал

Д.Эрдэнэчимэг

**Гэрээт ажилтан**

С.Алтанхуяг

**Зөвлөх шинжээч:**

Б.Мөнхзаяа

2021 оны 6 дугаар сар

Уг тайланг УАГ-ын

Цахим хуудаснаас үзнэ үү:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал  
51-261663 дугаарын утсаар  
харилцана уу.

**ХАЯГ:**

Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр,

Бага тойруу-6,

Улаанбаатар-46

Монгол Улс

## АГУУЛГА

ТУШААЛ .....	3
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....	4
Аудитын зорилт .....	4
Аудитын хамарсан хүрээ .....	4
Аудитын арга зүй .....	5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ .....	6
I БҮЛЭГ. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ .....	7
II БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ .....	9
2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж .....	9
2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл .....	11
2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл .....	13
2.4 Монгол Улсын Засгийн газрын өр .....	13
III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСӨВ .....	17
3.1 Улсын төсвийн орлого .....	17
3.2 Улсын төсвийн зарлага .....	19
3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, үр дүн .....	21
3.4 Улсын төсвийн тэнцэл .....	21
IV БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН 2020 ОНЫ ТӨСӨВ .....	22
4.1 Орон нутгийн төсвийн орлого .....	22
4.2 Орон нутгийн төсвийн зарлага .....	22
4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл .....	24
V БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....	25
5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого .....	25
5.2 Нийгмийн даатгалын сангийн зарлага .....	25
5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл .....	26
VI БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....	26
6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого .....	26
6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага .....	26
6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл .....	27
VII БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	27
VIII БҮЛЭГ. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ .....	28
8.1 Төсвийн орлогод үзүүлэх нөлөө .....	29
8.2 Төсвийн зарлагад үзүүлэх нөлөө .....	30
IX БҮЛЭГ. АУДИТЫН ОНЦЛОХ БУСАД АСУУДАЛ .....	31
ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	31
ДҮГНЭЛТ .....	32
Монгол улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд: .....	32
ЗӨВЛӨМЖ .....	33
Хавсралт 1 Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл .....	34
Хавсралт 2 Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл .....	35
Хавсралт 3 Нэгдсэн төсвийн тэнцэл .....	36
Хавсралт 4 Нэгдсэн төсвийн төлөвлөгөө ба гүйцэтгэл (ТЕЗ-аар) /тэрбум төгрөг/ .....	37
Хавсралт 5 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон макро эдийн засгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	39
Товчилсон үгийн жагсаалт .....	40



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3, 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

“Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-г хавсралтаар баталгаажуулсугай.

1. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Бундхорол/, Аудитын дөрөвдүгээр газар /Я.Самбууням/-т тус тус даалгасугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/, Сангийн сайд /Б.Жавхлан/ нарт тус тус зөвлөсүгэй.

3. Монгол Улсын Их хурал болон холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Наранчимэг/-д үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

**ЕРӨНХИЙ ЗҮЙЛ****Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1<sup>1</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2<sup>2</sup> дахь заалтын дагуу Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

**Аудитын зорилт**

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

**Аудитын хамарсан хүрээ**

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7<sup>3</sup>-д заасны дагуу Сангийн яамны бэлтгэсэн Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгад үндэслэн нийт 3336 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл
- Ирээдүйн өв сан
- Төсвийн тогтворжуулалтын сан
- НДС-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл
- ЭМДС-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн 2020 оны гүйцэтгэлийн тайлан
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Татварын зарлагын тайлан
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт
- Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын төсөвт үзүүлсэн нөлөө
- ТЕЗ-дын 2020 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүд.



Тайлбар: \* Төсвийн ерөнхийлөн захирагчийн тоо

\*\* Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тоо

<sup>1</sup>Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

<sup>2</sup> Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх

<sup>3</sup> Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын тайланд орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж тайлагнасан тул уг тайланд оруулаагүй болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### **Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын нөлөөг тодорхойлоход ашигласан үзүүлэлт, арга зүй**

Дэлхий нийтэд Коронавируст халдвар (Ковид-19)-ын өвчлөл цар тахлын хэмжээнд хүрч бүх нийтийн бэлэн байдал, хатуу хөл хориог удаа дараа тогтоосноос эдийн засаг суларч байгаад Засгийн газар Ковид-19 цогц бодлого боловсруулж Иргэдийн эрүүл мэнд, Иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг хамгаалах, Эдийн засгийг идэвхжүүлэх төсөв мөнгөний бодлого хэрэгжүүлсэн байна.

Эдийн засгийн уналтын эсрэг төсвийн зардлыг нэмэгдүүлэх замаар авч хэрэгжүүлсэн дээрх арга хэмжээ нь гадаад зээл, төсвийн орлого, зардалд үзүүлсэн нөлөөг тодорхойлох зорилгоор олон талын эх сурвалжаас нарийвчилсан судалгаа, тоо мэдээ, мэдээлэл, нотлох баримт цуглуулан нэгтгэн дүн шинжилгээ хийлээ.

Борлуулсан 2021.03.15

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсөв, тодотгосон төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Монголбанкны жилийн тайлан, Үндэсний Статистикийн хорооноос гаргасан “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээс тоймлон авч үзсэн болно.

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай холбоотой эдийн засгийн хориг арга хэмжээнүүдийн нөлөөгөөр ДНБ өмнөх оноос 322.2 тэрбум төгрөгөөр буурч 36,958.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан ба эдийн засгийн бодит өсөлт тайлант онд 5.3 хувиар агшиж, зорилтот түвшнээс 4.3 хувь, өмнөх оноос 10.4 нэгжээр тус тус буурсан байна.

Тайлант онд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл урьдчилсан гүйцэтгэлээр 16,399.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,200.0 тэрбум төгрөгөөр, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 8.4, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 6.1, төсвийн орлого өмнөх оноос 13.6 хувиар тус тус буурчээ.

Мөн нэгдсэн төсвийн нийт зарлага 19.2 хувиар өссөнөөс нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал 4,440.4 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь ДНБ-ий 12.0 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн тэнцлийн статистикаар нийт тэнцэл өмнөх онд 452.8 сая ам.долларын ашигтай байсан бол тайлант онд санхүүгийн данс 1,504.0 сая ам.долларын ашигтай гарч, урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 71.0 хувиар буурч, нийт тэнцэл 787.0 сая ам.долларын ашигтай гарсан нь ДНБ-ий 6.1 хувьтай тэнцэж байна.

Гадаад худалдааны тэнцэл 2,277.0 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 52.6 хувиар өсөж ДНБ-ий 17.6 хувьтай тэнцүү, экспорт 1.0 хувь, импорт 14.0 хувиар тус тус буурчээ.

Инфляцын түвшин жилийн эцсийн байдлаар 2.3 хувьтай гарч өмнөх оноос 2.9 нэгжээр, Монголбанкны зорилтот түвшнээс 5.7 нэгжээр бага үзүүлэлттэй байна. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ 2019 онд өмнөх оноос 7.0 хувиар буурч, тайлант онд 10.0 хувийн өсөлттэй байгаа нь цаашид хэрэглээний барааны үнийн түвшин нэмэгдэх эрсдэлтэй байна.

Монголбанк тайлант онд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 23.6 тн үнэт металлыг худалдан авч оны эцэст гадаад валютын албан нөөц 4,534.2 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 4.3 хувиар буюу 185.6 сая ам.доллаароор өсжээ.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл оны эцэст 32,362.0 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 5.0 хувиар буюу 1,660.0 сая ам.доллаароор өссөн, Засгийн газрын нийт өр (ӨҮЦ) өмнөх оноос 19.9 хувиар өсөж 8,654.0 сая ам.долларт хүрсэн нь ДНБ-ий 62.3 хувийг эзэлж байна.

## I БҮЛЭГ. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах харилцааг “Төсвийн тогтвортой байдлын тухай” болон “Төсвийн тухай” хуулиар зохицуулдаг.

1.2 Улсын Их Хурлаар “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийг анх баталснаас хойш дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт саарч, нэгдсэн төсвийн нийт орлого эхний хагас жилд 4,358.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1,212.2 тэрбум төгрөг буюу 28 орчим хувиар буурч сүүлийн хагас жилд ч бууралт үргэлжлэх төлөвтэй байснаас шалтгаалан төсөвт тодотгол хийсэн байна.

1.3 Засгийн газраас эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээнүүдийг он дуустал үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийг тусган Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд дахин өөрчлөлтийг оруулан баталжээ.

## Хүснэгт 1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл			Өөрчлөлт /өмнөх түвшнээс/	
	Анх баталсан /2019.05.30/	Өөрчлөн баталсан 2019.11.13/	Тодотгол /2020.08.28/	Анх баталснаас	Тодотголоос
ДНБ-ний бодит өсөлт /хувь/	6	6	-1	-7	-7
Хэрэглээний үнийн өсөлт	8	8	3.8	-4.2	-4.2
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хэмжээ /тэрбум төгрөг/	11,122.6	11,797.8	9,730.9	-1,391.7	-2,066.9
ДНБ-д эзлэх хувь	27.3	29.0	25.2	-2.1	-3.8
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	13,197.4	13,872.6	14,577.5	1,380.1	704.9
ДНБ-д эзлэх хувь	32.4	34.1	37.7	5.3	3.6
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,608.3	2,283.5	704.9	2,987.7	2,987.7
ДНБ-д эзлэх хувь	4.0	5.6	1.8	-2.2	-3.8
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,074.7	-2,074.7	-4,846.6	-2,771.9	-2,771.9
ДНБ-д эзлэх хувь	-5.1	-5.1	-12.5	-7.4	-7.4
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,491.4	3,806.1	3,408.0	-83.4	-398.1
ДНБ-д эзлэх хувь	8.6	9.4	8.8	0.2	-0.6
Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,089.1	22,089.1	24,065.8	1,976.7	1,976.7
ДНБ-д эзлэх хувь	54.3	54.3	62.2	7.9	7.9
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	750.2	756.6	1,650.2	900.0	893.6
ДНБ-д эзлэх хувь	1.8	1.9	4.3	2.5	2.4

1.4 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг анх баталснаас 12.5 хувиар буюу 1,391.7 тэрбум төгрөгөөр бууруулж 9,730.9 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг анх баталснаас 10.4 хувиар нэмэгдүүлж 14,577.5 тэрбум төгрөгөөр баталсан байна.

1.5 Мөн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээг нийт 2,987.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн зардлыг 398.1 тэрбум төгрөгөөр бууруулж, нийт зарлагын дээд хэмжээг 704.9 тэрбум, төсвөөс санхүүжүүлэх халамжийн зардлыг 893.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

1.6 Төсвийн төслийг боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах бүрд төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчилж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 4.1.10, 7 дугаар зүйлийн 7.3-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Төсвийн  
төлөвлөлтМонгол Улсын  
2020 оны нэгдсэн  
төсөвМонгол Улсын  
2020 оны төсөвОрон нутгийн  
2020 оны төсөвНДС, ЭМДС-ийн  
2020 оны төсөвКовид-19 цар  
тахлын төсөв  
үзүүлэх нөлөөАудитын онцлох  
бүсэд асуудалДүгнэлт,  
зөвлөмж

1.7 Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэн, төсвийг эрүүлжүүлэх, алдагдлыг үе шаттай бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ;
- Засгийн газрын 2012-2016 онд гаргасан бондуудыг эргэн төлөхтэй холбогдуулан төсвийн алдагдлыг хуульд заасан хэмжээнээс сайжруулж, 2023 оноос ашигтай гаргах бодлого баримтална;
- Засгийн газрын зүгээс 2021-2024 онуудад төлөгдөх нийт 2.9 тэрбум ам.долларын өндөр хүүтэй гадаад үнэт цаасны эргэн төлөлтийг эдийн засаг, төсөвт дарамт үүсгэхгүй байхаар өрийн менежментийг хэрэгжүүлнэ;
- Бизнес, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн татварын шинэчлэлийг хэрэгжүүлнэ;
- Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж дуусгаснаар гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах боломжийг бүрдүүлнэ;
- Зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр ашиг хүртээмжийг нэмэгдүүлнэ;
- Өмнөх жилүүдэд эхлүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусгаж, нийгэмд тулгамдсан төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлнэ;
- “Сумын төвийн шинэчлэл”-ийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, бүс тус бүрээс нэг сумыг хамруулна.

1.8 Нэгдсэн төсвийн бодлогод дэвшүүлсэн 2 зорилт хэрэгжиж дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 6 зорилтын хэрэгжилт хангалтгүй, дунд хугацаанд хэрэгжихээр хойшлогдсон байна.

1.9 Мөн төсвийн тодотгол хийхдээ дараах зарчмуудыг баримталсан байна.

Үүнд:

- Иргэд, аж ахуй нэгжийг үргэлжлүүлэн дэмжинэ;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангана;
- Экспортыг нэмэгдүүлнэ;
- Цахим шилжилтийг хурдасгана;
- Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлнэ.

Дээрх зарчмуудаас хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлэх зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй, бусад зарчмуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.10 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын “Урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах” гэсэн Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим хангагдаагүй байна.

1.11 Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 3,222.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,866.7<sup>4</sup> тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэн тайлагнажээ.

<sup>4</sup> Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 358.9 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 175.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн;

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийг нийт 1,789.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 1,701.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн;

ЭМДС-аас улсын эмнэлгүүдэд олгосон татаасыг 277.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 221.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн, НДШ-ийн зардалд 298.1 тэрбум төгрөг төлөвлөгдөж, 282.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан бол, Улсын төсвөөс НДС-д олгох татаасыг 497.2 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 485.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн, ЭМДС-аас НДС-д олгох татаасыг 1.1 тэрбум төгрөгөөр төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

## II БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

## 2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж

2.1.1 Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 10,444.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 438.8 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй, өмнөх оноос 1,596.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

## Хүснэгт 2 Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он		2020 он			Өмнөх оны зөрүү
	Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>12,040.3</b>	<b>10,883.0</b>	<b>10,444.2</b>	<b>-438.8</b>	<b>96.0</b>	<b>-1,596.1</b>
Тогтворжуулалтын сан	94.6	55.2	66.2	11.0	119.9	-28.4
Ирээдүйн өв сан	1,040.2	943.2	914.1	-29.1	96.9	-126.1
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн*</b>	<b>10,905.5</b>	<b>9,884.6</b>	<b>9,463.9</b>	<b>-420.7</b>	<b>95.7</b>	<b>-1,441.6</b>
Татварын орлого	9,813.2	8,905.9	8,511.7	-394.2	95.6	-1,301.5
Татварын бус орлого	1,092.3	978.7	952.2	-26.5	97.3	-140.1
Үүнээс:						
Улсын төсвийн орлого	9,112.4	8,474.9	7,809.4	-665.5	92.1	-1,303.0
Орон нутгийн төсвийн орлого	2,947.6	3,311.7	3,146.8	-164.9	95.0	199.2
НДС-ийн орлого	2,485.0	1,812.2	1,878.2	66.0	103.6	-606.8
ЭМДС-ийн орлого	469.6	506.5	476.5	-30.0	94.1	6.9

/\*Цэвэр дүнгээр/

2.1.2 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 90.6 хувийг нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж, 8.8 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлсэн орлого, 0.6 хувийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлсэн орлого эзэлж байна.

2.1.3 Мөн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн 58.7 хувийг улсын, 23.6 хувийг орон нутгийн, 14.1 хувийг НДС-ийн, 3.6 хувийг ЭМДС-ийн орлого бүрдүүлжээ.

2.1.4 Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого төлөвлөснөөс 20.0 хувиар буюу 11.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь коксжих нүүрсний зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс дунджаар 32.1 ам.доллаар, сүүлийн хагас жилд зэсийн зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс дунджаар 557.2 ам.доллаар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

2.1.5 Тус сангаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 138.8 тэрбум төгрөгийг зарцуулж оны эцэст үлдэгдэлгүй байна.

2.1.6 Ирээдүйн өв санд 943.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 914.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар дутуу төвлөрүүлсэн 30.0 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

2.1.7 Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу<sup>5</sup> 2017-2019 онуудад нийт 310.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, ХХС-ийн хуримтлагдсан өр 1,071.9 тэрбум төгрөгийг барагдуулж дууссан ба тайлант онд 1,414.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 145.0 тэрбум төгрөгийн авлагатай нийт хуримтлал 1,559.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2.1.8 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж өмнөх оноос 1,441.6 тэрбум төгрөгөөр буурахад дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас Засгийн газраас авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээ<sup>6</sup> голлон нөлөөлжээ.

<sup>5</sup> Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд "Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1, 7.1.2-т заасны дагуу бүрдүүлсэн сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2017 онд 160 тэрбум төгрөг, 2018 онд 100 тэрбум төгрөг, 2019 онд 50 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус шилжүүлнэ", 3 дугаар зүйлд "Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан шилжүүлэг болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9.1, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон Корпорацийн зардлыг шилжүүлсний дараа үлдэх эх үүсвэрээр энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан Ирээдүйн өв сангийн өглөгийг төлж барагдуулна"

<sup>6</sup> Монгол Улсын коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай тогтоол;

Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114 дүгээр тогтоол.

Хүснэгт 3 Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны биет хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, нийт орлого

2.1.9 Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор<sup>7</sup> эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр 406.3 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламж тодотгосон төсвөөс 420.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд голлон нөлөөлсөн байна.

Үүнээс татварын орлого төлөвлөснөөс 4.4 хувиар буюу 394.2 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оноос 1,301.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

2.1.10 Татварын орлогын дутуу биелэлтэд НДС-ийн орлого 66.0 тэрбум, онцгой албан татвар 42.0 тэрбум төгрөгөөр давж, орлогын албан татвар 338.0 тэрбум, НӨАТ 69.0 тэрбум, хөрөнгийн албан татвар 20.4 тэрбум, импорт экспортын гаалийн татвар 30.2 тэрбум, бусад татвар 44.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлжээ.

**Зураг 1 Татварын ачаалал ба татварын орлого /тэрбум төгрөг/ 2016-2020 он**



2.1.11 Татварын орлогын ДНБ-д эзлэх ачаалал 23.0 хувьд хүрч өмнөх оноос 3.6 хувиар буурчээ. Мөн татварын дундаж ачаалал 25.3 хувиас 2.3 нэгжээр бага гарч 2014-2017 оны түвшинд очсон нь иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс шалтгаалсан байна.

2.1.12 Уул уурхайн салбарын орлого 2,802.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 5.6 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй, экспортын биет хэмжээ<sup>8</sup> цар тахалтай холбоотойгоор багасаж, өмнөх оноос 336.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.1.13 Уул уурхайн бүтээгдэхүүний орлого өмнөх оноос 336.4 тэрбум төгрөгөөр буурсан нь биет хэмжээгээр зэсийн баяжмалын экспорт 8.5 мянган.тн, нүүрсний экспорт 8.0 сая.тн, боловсруулаагүй нефтийн экспорт 2,474.7 мянган.баррелиар буурснаас шалтгаалжээ.

2.1.14 Нэгдсэн төсвийн нийт орлогын 26.8 хувийг уул уурхайн бүтээгдэхүүнд ногдох татварын орлого эзэлж байгаа ба өмнөх оноос 10.7 хувиар буурсан байна.

2.1.15 Уул уурхай, газрын тосны салбарын 2020 оны нийт орлогын 45.2 хувийг АМНАТ, 24.4 хувийг ААНОАТ, 1.7 хувийг НӨАТ, 28.7 хувийг бусад татварын болон татварын бус орлого бүрдүүлсэн байна.

**Хүснэгт 3 Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны биет хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, нийт орлого**

Бүтээгдэхүүний нэр төрөл	х/н	Биет хэмжээ			Үнэ, ам доллар/нэгж			Нийт орлого /тэрбум төгрөг/		
		2019 он гүйц	2020 он		2019 он гүйц	2020 он		2019 он гүйц	2020 он	
			Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		төлөв	Гүйц
Алт	тн	13.2	19.0	30.5	1,389.6	1,735.0	1,765.3	116.8	205.5	174.0
Зэсийн баяжмал	мян. тн	1,403.6	1,225.0	1,395.1	6,004.6	5,940.9	6,168.5 <sup>9</sup>	1,333.3	1,122.8	1,266.3
Төмрийн хүдэр	мян. тн	8,448.8	8,280.0	8,202.3	68.3	69.0	78.0	47.5	90.8	105.2
Нүүрс	сая. тн	36.7	42.0	28.7	84.5	75.0	74.2	1,282.2	1,056.3	877.7
Боловсруулаагүй нефть	мян. бар	6,545.2	6,235.0	4,070.5	56.0	35.6	37.1	231.6	110.0	102.7
Бусад								127.1	222.3	276.2
<b>Дүн</b>								<b>3,138.5</b>	<b>2,807.7</b>	<b>2,802.1</b>

<sup>7</sup>Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоол;

<sup>8</sup> Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын шийдвэрээр 2020 оны хоёрдугаар сард БНХАУ-тай харилцан хилийн боомтоо хааж, гадаад худалдааг зогсоосноор 4 дүгээр сарын байдлаар экспорт өмнөх оны мөн үеэс 45.3 хувиар буурсан. Засгийн газар 8 дугаар сард БНХАУ-ын талтай “Ногоон гарц” түр журмыг боловсруулан хэрэгжүүлснээр сард дунджаар 50 орчим нүүрсний машин хилээр гардаг байсныг дунджаар 1650 болгож нэмэгдүүлсэн;

<sup>9</sup> Төсвийн тогтворжуулалтын санд сүүлийн 6 дугаар сард хуваарилсан зэсийн зах зээлийн дундаж үнэ 6,847.4 ам.доллар байсан.

2.1.16 Тайлант онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт гүйцэтгэлээр 1,218.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 6.0 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн<sup>10</sup> боловч өмнөх онтой харьцуулахад 207.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

## 2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

2.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны Төсвийн хүрээний мэдэгдлээр нийт зарлагын дээд хэмжээг 13,872.6 тэрбум төгрөгөөр баталсныг 704.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 14,577.5 тэрбум төгрөг болгон тодотгожээ.

### Хүснэгт 4 Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жилийн хязгаар	УИХ-д өргөн барьсан	2020 он			
			Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү	Хувь
<b>НЭГДСЭН ТӨСӨВ*</b>		<b>13,866.6</b>	<b>13,872.6</b>	<b>14,577.5</b>		
Улсын төсөв	10,525.0	10,852.3	10,852.3	11,653.3	327.3	103.1
Орон нутгийн төсөв	3,138.3	3,299.7	3,305.7	3,160.3	161.4	105.1
НДС-ийн төсөв	2,430.6	2,510.7	2,510.7	2,494.0	80.1	103.3
ЭМДС-ийн төсөв	509.1	506.5	506.5	494.5	-2.6	99.5

/\*Цэвэр дүнгээр/

2.2.2 Улсын төсвийн төслийг батлагдсан хязгаараас 327.3 тэрбум, НДС-ийн төсвийг 80.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, ЭМДС-ийн төсвийг 2.6 тэрбум төгрөгөөр бууруулан Улсын Их Хуралд өргөн барьсан байна.

2.2.3 Засгийн газраас цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан төсвийн тодотголоор нийт зардлыг 673.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр хуулийн төслийг боловсруулсан боловч төслөөс 127.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 801.0 тэрбум төгрөгөөр баталсан байна.

#### Тухайлбал:

ХНХС 832.3 тэрбум, ЗГХЭГ 362.0 тэрбум, Сангийн сайд 208.4 тэрбум, ХХААХҮС 166.3 тэрбум, ЭМС 94.1 тэрбум, ШС 3.7 тэрбум, МУЕТГ, УИХ, ХЭҮК зэрэг төсөв захирагчдын төсвийг нийт 0.9 тэрбум төгрөгөөр нэмж, БШУС 484.9 тэрбум, МУЕС 310.4 тэрбум, ЗТХС 96.2 тэрбум, БХБС 73.4 тэрбум төгрөгөөр тус тус хасаж тодотгосон байна.

### Хүснэгт 5 Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Анх батлагдсан		Тодотгол		Зөрүү	
	Нэгдсэн	Улсын	Нэгдсэн	Улсын	Нэгдсэн	Улсын
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,872.6</b>	<b>10,852.3</b>	<b>14,577.5</b>	<b>11,653.3</b>	<b>704.9</b>	<b>801.0</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>10,019.4</b>	<b>7,622.5</b>	<b>11,150.9</b>	<b>8,808.6</b>	<b>1,131.5</b>	<b>1,186.1</b>
1. Бараа, үйлчилгээний зардал	4,785.5	2,946.1	4,958.1	3,156.4	172.6	210.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	959.8	959.8	972.6	972.6	12.8	12.8
3. Татаас ба урсгал шилжүүлэг	4,274.1	3,716.6	5,220.2	4,679.6	946.1	963.0
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,806.1</b>	<b>3,182.7</b>	<b>3,408.0</b>	<b>2,826.1</b>	<b>-398.1</b>	<b>-356.6</b>
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>47.1</b>	<b>47.1</b>	<b>18.6</b>	<b>18.6</b>	<b>-28.5</b>	<b>-28.5</b>

2.2.4 Үүнээс улсын төсвийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 893.6 тэрбум, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 129.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газрын дотоод шилжүүлгийг 57.0 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

2.2.5 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө Төсвийн хүрээний мэдэгдлээр баталснаас 557.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн ИТХ-аар баталсан төсвөөр Сангийн яамны хянасан суурь зарлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

2.2.6 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 13,904.3 тэрбум төгрөгт хүрч, 91.9 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 2,242.6 тэрбум төгрөгөөр өссөн нь төсвийн урсгал зарлага 7.8-21.5 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

<sup>10</sup> Тайлант оны зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 6,290.2 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 75.5 ам.доллар байхаар тус тус тооцсон.

## Хүснэгт 6 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн эдийн засгийн ангилал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он		2020 он			Өмнөх оны зөрүү
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн*</b>	<b>11,661.7</b>	<b>15,137.3</b>	<b>13,904.3</b>	<b>91.9</b>	<b>-1,233.0</b>	<b>2,242.6</b>
<b>Урсгал зарлага</b>	<b>8,228.6</b>	<b>11,569.0</b>	<b>10,828.9</b>	<b>93.6</b>	<b>-740.1</b>	<b>2,600.3</b>
Бараа, үйлчилгээний зардал	4,000.5	5,257.9	4,851.3	92.3	-406.6	850.8
Хүү	861.0	979.0	939.2	95.9	-39.8	78.2
Татаас ба урсгал шилжүүлэг	3,367.1	5,332.1	5,038.4	94.5	-293.7	1,671.3
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>3,016.7</b>	<b>3,514.0</b>	<b>3,034.3</b>	<b>86.3</b>	<b>-479.7</b>	<b>17.6</b>
<b>Эргэж төлөгдөх цэвэр зээл</b>	<b>416.4</b>	<b>54.3</b>	<b>41.1</b>	<b>75.7</b>	<b>-13.2</b>	<b>-375.3</b>
Үүнээс						
Улсын төсөв	9,295.1	11,653.3	10,735.6	92.1	-917.7	1,440.5
Орон нутгийн төсөв	2,927.7	3,717.9	3,157.2	84.9	-560.7	229.5
НДС-ийн төсөв	2,062.3	2,494.0	2,451.8	98.3	-42.2	389.5
ЭМДС-ийн төсөв	351.0	494.5	426.4	86.2	-68.1	75.4

/\*Цэвэр дүнгээр/

2.2.7 Нийт зарлага ба цэвэр зээл өмнөх оноос 2,242.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс 1,122.9 тэрбум төгрөг нь цар тахалтай холбоотой зардал байна.

2.2.8 Улсын төсвийн зардлыг 917.7 тэрбум, орон нутгийн төсвийн зардлыг 560.7 тэрбум, НДС-ийн төсвийн зардлыг 42.2 тэрбум, ЭМДС-ийн төсвийн зардлыг 68.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

2.2.9 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг үндэслэн төсөвт тодотгол хийгдэхээс өмнө ТЕЗ хооронд 603.4 тэрбум төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

2.2.10 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал 41.1 тэрбум төгрөг буюу 75.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.11 Эргэж төлөгдөх цэвэр зээл 170.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс, 119.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд 5 ТЕЗ-д нийт 63.8 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 183.3 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

## Хүснэгт 7 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл /тэрбум төгрөг/

ТЕЗ	Төсөл хөтөлбөрийн нэр	2020 он		Зөрүү	Хувь
		Төлөв	Гүйц		
<b>Олгосон зээл, үүнээс</b>		<b>134.9</b>	<b>63.8</b>	<b>71.1</b>	<b>96.2</b>
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	50.4	22.8	27.6	45.2
	Хөдөө аж ахуйг дэмжих сан	21.4	7.2	14.2	33.6
БШУС	Боловсролын зээлийн сан	20.9	11.0	9.9	52.6
БХБС	"Түрээсийн орон сууц" хөтөлбөр	5.0	5.0	-	100.0
Сангийн сайд	Олон Улсын хөрөнгө оруулалтын банк	1.5	-	1.5	-
Орон нутаг	17 аймгийн ТЕЗ	35.7	17.8	17.9	49.9
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		<b>-305.1</b>	<b>-183.3</b>	<b>-121.8</b>	<b>60.1</b>
ХХААХҮС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	-41.0	-6.7	-34.3	16.3
	Хөдөө аж ахуйг дэмжих сан төсвийн зээл	-28.0	-3.7	-24.3	13.2
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл	-215.5	-172.9	-42.6	80.2
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	-20.6	-	-20.6	-
Эргэж төлөгдөх зээлийн дүн		<b>-170.2</b>	<b>-119.5</b>	<b>-50.7</b>	<b>70.2</b>
Үүнээс: Гадаад эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх зээлийн дүн		224.5	160.6	63.9	71.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		54.3	41.1	13.2	75.7

2.2.12 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийг 305.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс, 60.1 хувь буюу 121.8 тэрбум төгрөгийн дутуу төвлөрүүлжээ. Тухайлбал, ХХААХҮС 58.6 тэрбум, Сангийн сайд 42.6 тэрбум, ХЗДХС 20.6 тэрбум төгрөг байна.

2.2.13 Нийт дамжуулан зээлээс 185.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, Сангийн сайд 13.2 тэрбум, БШУС 2.8 тэрбум, ХХААХҮС 58.5 тэрбум, нийт 69.0 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

## 2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

2.3.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 5,252.7 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 812.3 тэрбум төгрөгөөр буурч 4,440.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь ДНБ-ий 12.0 хувьтай тэнцэж байна.


### Хүснэгт 8 Нэгдсэн төсвийн тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2019 он		2020 он		
	Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
<b>Нэгдсэн төсөв</b>	<b>-756.2</b>	<b>-5,252.7</b>	<b>-4,440.4</b>	<b>812.3</b>	<b>84.5</b>
Улсын төсөв	-1,317.5	-4,176.7	-3,906.5	270.2	93.5
Орон нутгийн төсөв	19.9	-406.2	-10.4	395.8	2.6
НДС-ийн төсөв	422.7	-681.8	-573.6	108.2	84.1
ЭМДС-ийн төсөв	118.7	12.0	50.1	38.1	417.5

2.3.2 Тайлант онд нэгдсэн төсвийн дутагдлыг нөхөхөд зориулж хөтөлбөрийн зээлээс 1,978.0 тэрбум, Тогтворжуулалтын сангаас 138.8 тэрбум, өмч хувьчлалын орлогоос 21.2 тэрбум, гадаад өрийг дахин санхүүжүүлэхэд 1,692.6 тэрбум, төслийн зээлийн ашиглалт 1,374.4 тэрбум, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлээс 1,868.4 тэрбум төгрөг, нийт 7,073.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

2.3.3 Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 1,679.0 тэрбум, гадаад зээлийн үндсэн төлбөрт 691.1 тэрбум, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 263.0 тэрбум, төсвийн дутагдлыг санхүүжүүлэхэд 4,440.4 тэрбум төгрөг, нийт 7,073.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

### Зураг 2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын харьцаа



2.3.4 Мөн сүүлийн 5 жилийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн дундаж зарлагын өсөлтийн хувь, дундаж орлогын өсөлтийн хувиас 3.6 нэгжээр их, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн 1 төгрөгийн орлого тутамд 1.47 төгрөгийн зардал гарсан нь өмнөх оноос 37.4 хувиар өсжээ.

## 2.4 Монгол Улсын Засгийн газрын өр

2.4.1 Засгийн газрын ӨҮЦ-ээр илэрхийлсэн өр оны эцэст 23,024.3 тэрбум төгрөгт хүрч ДНБ-ий 62.3 хувьтай тэнцүү байна.

### Хүснэгт 9 Засгийн газрын өр /тэрбум төгрөг/

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	2016.12.31	2017.12.31	2018.12.31	2019.12.31	2020.12.31
I. Засгийн газрын дотоод өр	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6
1.1 Үнэт цаас	5,488.8	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6
1.2 Өрийн бичиг/вексель	307.2	0.0	0.0	0.0	0.0
II. Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	18,865.6	20,728.1	24,851.4
2.1 Үнэт цаас	5,380.5	7,701.6	7,664.5	7,927.2	8,354.0
2.2 Зээл	6,983.3	9,156.2	11,201.1	12,800.9	16,497.4
III. Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.7	1,130.7	1,076.3	1,060.4
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс	668.9	768.2	806.0	995.7	850.2
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР</b>	<b>22,280.1</b>	<b>22,751.6</b>	<b>22,367.0</b>	<b>24,199.7</b>	<b>27,898.6</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>	<b>18,861.0</b>	<b>20,212.1</b>	<b>18,955.9</b>	<b>20,525.6</b>	<b>23,024.3</b>
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0%	85.0%	80.0%	75.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	78.8%	72.5%	58.9%	55.6%	62.3%
Засгийн газрын өр/ДНБ	93.1%	81.6%	69.0%	64.9%	75.5%
Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд:					
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)*	23,942.9	27,876.3	32,411.2	37,280.8	36,958.6
Ам.долларын тайлант үеийн эцсийн ханш	2,489.53	2,427.13	2,642.92	2,733.52	2,849.51

2.4.2 Засгийн газрын өр өмнөх оноос 15.3 хувь буюу 3,698.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар<sup>11</sup> тогтоосон төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

2.4.3 Өрийн стратегийн баримт бичгийн<sup>12</sup> хэрэгжилтийг хангаж<sup>13</sup> өрийн хэрэгслийн гэрээг шинээр байгуулаагүй, дотоод үнэт цаас, өрийн баталгаа, концессын нийт өр 424.5 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 10 Засгийн газрын 2020 оны өрийн бүтэц /тэрбум төгрөг/

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Хүүгийн төлбөр	Эцсийн үлдэгдэл
I. Засгийн газрын дотоод өр	1,399.6	-	263.0	-	157.1	1,136.6
1.1 Үнэт цаас	1,399.6	-	263.0	-	157.1	1,136.6
II. Засгийн газрын гадаад өр	20,728.1	5,081.2	2,313.2	1,355.4	775.8	24,851.4
2.1 Үнэт цаас	7,927.2	1,712.7	1,622.1	336.2	577.8	8,354.0
2.2 Зээл	12,800.9	3,368.4	691.1	1,019.2	197.9	16,497.4
III Засгийн газрын өрийн баталгаа	1,076.3	1.9	106.3	88.4	27.4	1,060.4
IV Барих-шилжүүлэх төрлийн концесс	995.7	121.4	322.6	55.6	0.0	850.2
Нийт	24,199.7	5,204.5	3,005.1	1,499.5	960.2	27,898.6

2.4.4 Засгийн газрын гадаад өр валютын ханшийн<sup>14</sup> тэгшитгэлийн өөрчлөлтөөс шалтгаалан 1,499.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

2.4.5 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 1,136.6 тэрбум төгрөг болж 263.0 тэрбум төгрөгөөр буурсан, шинээр дотоод үнэт цаас гаргаагүй байна.

2.4.6 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн арилжааг 2012 оноос Монголбанкаар, 2014 оноос Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалсан боловч үнэт цаасны дийлэнх хэсгийг томоохон арилжааны банкнууд өндөр хүүтэй эзэмшиж төсвийн мөнгөн хөрөнгөд төлбөрийн дарамт учруулж байсан тул 2017 оны 4 дүгээр улирлаас хойш Засгийн газрын дотоод үнэт цаас гаргахыг зогсоосноос төсвийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан дотоод үнэт цаас буурсан байна.

2.4.7 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 727.6 тэрбум төгрөг буюу 64.0 хувийг төсвийн дутагдлыг, 374.0 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг, 35.0 тэрбум төгрөг буюу 3.1 хувийг ХХС-ийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

2.4.8 Гадаад үнэт цаас Номад бондын 1,712.7 тэрбум, ханшийн тэгшитгэлийн зөрүү 336.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, буцаан худалдан авсан бондын 1,622.1 тэрбум төгрөгөөр хасагдаж өмнөх оноос 426.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### Зураг 3 Засгийн газрын өрийн бүтэц



2.4.9 Засгийн газрын нийт өрийн өсөлтийн хувь 2017-2019 онд огцом буурсан нь өрийн стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж дотоод үнэт цаас, өрийн баталгаа, концессын өр шинээр үүсгээгүйтэй холбоотой байна.

2.4.10 Харин өмнөх оноос 15.3 хувиар өссөн нь төсөл хөтөлбөрийн зориулалтаар 3,368.4 тэрбум төгрөгийн гадаад зээл шинээр авснаас шалтгаалжээ.

2.4.11 Гадаад зээл, үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн зөрүүнээс үүссэн

<sup>11</sup> Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Засгийн газрын 2020 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 4,850,755.9 сая төгрөгөөр баталсугай" гэж заасан;

<sup>12</sup> Монгол Улсын Их Хурлын 55 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-ийн нэгдүгээр зорилтод "Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна";

<sup>13</sup> Монгол Улсын Их Хурлын 55 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-ийн дөрөвдүгээр зорилтод "Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.б-д заасан Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг 2018 оноос нэмэгдүүлэхгүй байх бодлогыг баримтална", Барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулах, өрийн бичиг бичих зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримтална";

<sup>14</sup> Монголбанкны хаалтын ханш 1 ам.доллар 2,849.51 төгрөг.

алдагдал сүүлийн 5 жилд дунджаар 1,137.6 тэрбум, тайлант онд 1,355.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа нь ирээдүйд төлөх өрийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна

### Засгийн газрын гадаад үнэт цаас

2.4.12 Тайлант онд Засгийн газрын гадаад үнэт цаас 426.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийт өрийн 29.9 хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 11 Засгийн газрын гадаад үнэт цаас /тэрбум төгрөг/

Гадаад үнэт цаас	Хүүгийн хувь	Эхний үлдэгдэл		Шинэ тэрбум төгрөг	Эргэн төлөлт тэрбум төгрөг	Ханшийн алдагдал /тэрбум төгрөг/	Эцсийн үлдэгдэл		Эргэн төлөх огноо
		сая ам. доллар	тэрбум төгрөг				сая ам. доллар	тэрбум төгрөг	
Чингис	5.125	1,000.0	2,733.5	-	573.2	117.0	799.2	2,277.3	2022
Гэрэгэ	5.625	800.0	2,186.7	-	-	92.9	800.0	2,279.6	2023
Хуралдай	8.750	600.0	1,640.2	-	-	69.5	600.0	1,709.7	2024
Мазаалай	10.875	500.0	1,366.8	-	1,048.9	59.8	132.6	377.7	2021
Номад	5.125	-	-	1,712.7	-	-3.0	600.0	1,709.7	2026
<b>Нийт дүн</b>		<b>2,900.0</b>	<b>7,927.2</b>	<b>1,712.7</b>	<b>1,622.1</b>	<b>336.2</b>	<b>2,931.8</b>	<b>8,354.0</b>	

2.4.13 Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолоор<sup>15</sup> Номад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 5.125 хувийн хүүтэй 5.5 жилийн хугацаатай 600.0 сая ам.доллар буюу 1,712.7 тэрбум төгрөгийн бондыг Олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалжээ.

2.4.14 Дээрх бондоор 2021 онд эргэн төлөгдөх 10.875 хувийн хүүтэй 367.4 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 онд эргэн төлөгдөх 5.125 хувийн хүүтэй 200.8 сая ам.долларын Чингис бонд нийт 1,622.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө худалдан авсан байна.

2.4.15 Гадаад үнэт цаасны багцын жигнэсэн дундаж хүү 6.26 хувь байгаагаас Мазаалай бондын хүү 10.875, Хуралдай бондын хүү 8.75 хувтай байна.

### Засгийн газрын гадаад зээл

2.4.16 Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт өмнөх оноос 1,450.2 тэрбум, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээс 1,019.2 тэрбум төгрөгөөр өсөж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн 59.1 хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 12 Засгийн газрын гадаад зээл /тэрбум төгрөг/

Салбарын ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
		Ашиглалт	Ханшийн зөрүү	Үндсэн төлбөр		
Төслийн зээл	8,693.8	1,390.4	727.8	314.1		10,497.9
Хөтөлбөрийн зээл	3,088.1	1,978.0	225.0	67.6		5,223.5
Арилжааны зээл	426.4	0.0	15.4	270.8		171.0
Санхүүгийн зээл	592.5	0.0	51.1	38.6		605.0
<b>Нийт дүн</b>	<b>12,800.9</b>	<b>3,368.4</b>	<b>1,019.2</b>	<b>691.1</b>		<b>16,497.4</b>

2.4.17 Засгийн газар ОУ-ын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төслийн зээл 1,390.4 тэрбум, Ковид-19 хөтөлбөрийн 1,532.8 тэрбум, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрөөс төсвийн дэмжлэг 445.2 тэрбум нийт 3,368.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

2.4.18 ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр 2017 оноос эхлэн хэрэгжиж 2,384.3 сая ам.долларын санхүүжилтийн эрх олгогдсоноос 1,329.2 сая ам.долларын дэмжлэг авч, 1,055.1 сая ам.долларын эх үүсвэрийг ашиглаагүй байна.

2.4.19 Мөн гадаад зээлийн үндсэн төлбөрт 724.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 691.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, хүүгийн төлбөрт 197.9 тэрбум төгрөг төлсөн байна.

2.4.20 Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй 9 төсөлд 167.3 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт гарсан байна.

<sup>15</sup>Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн "Засгийн газрын гадаад өрийн зохицуулалт хийх арга хэмжээний тухай" 102 дугаар тогтоолоор Өрийн үйлчилгээний зардлын төсөөт үзүүлэх ачааллыг урт хугацаанд жигдлэх, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалж, Засгийн газрын 2021 онд эргэн төлөгдөх Мазаалай, 2022 онд эргэн төлөгдөх Чингис бондын тодорхой хэсгийг хөрөнгө оруулагчдаас дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

**Засгийн газрын гадаад өрийн баталгаа**

2.4.21 Засгийн газрын өрийн баталгааны эргэн төлөлт 106.3 тэрбум төгрөгөөр буурч, 1.9 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээр 88.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 1,060.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 13 Засгийн газрын гадаад өрийн баталгаа /тэрбум төгрөг/**

Дугаар	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Үндсэн төлбөр	Эцсийн үлдэгдэл	
				Ашиглалт	Ханш		Төгрөг /тэрбум/	Ам.доллар /сая/
<b>I. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАРГАСАН</b>								
МИАТ-1	МИАТ ХК	PEFCO	72.4	-	2.8	22.9	52.3	18.3
МИАТ-2	МИАТ ХК	ING Capital	7.0	-	0.2	7.2	-	-
DBM-30	МУХБанк	Japan Investors	751.2	-	76.2	-	827.4	290.4
DBM-162	МУХБанк	China Dev. bank	221.4	-	8.3	75.8	153.9	54
EM-35	Эрдэнэс Монгол ХХК	ADB	24.3	1.9	1.0	0.4	26.8	9.4
<b>НИЙТ</b>			<b>1,076.3</b>	<b>1.9</b>	<b>88.5</b>	<b>106.3</b>	<b>1,060.4</b>	<b>372.1</b>
<b>II. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСААР БАТАЛГААЖСАН</b>								
<b>TDB-500[1]</b>	<b>ХХБ</b>	<b>ОУ-ын ХО</b>	<b>1,366.8</b>			<b>1,366.8<sup>16</sup></b>	<b>-</b>	<b>-</b>

**Барих-шилжүүлэх төрлийн концесс**

2.4.22 Эргэн төлөх концессын өрийн ашиглалт тайлант онд 145.5 тэрбум төгрөгөөр буурч, 850.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх 10 гэрээний үлдэгдэл 849.5 тэрбум, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх 6 гэрээний үлдэгдэл 0.7 тэрбум төгрөг байна.

<sup>16</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй" гэж заасан тул Худалдаа хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа нь өрийн хязгаарт тооцогдохгүй болно.

## III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСӨВ

## 3.1 Улсын төсвийн орлого

3.1.1 Тайлант онд улсын төсвийн нийт орлого ба тусламжийг 8,474.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 7,809.4 тэрбум төгрөг буюу 92.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 14 Улсын төсвийн нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он		2020 он			Өмнөх оны зэрүү
	Гүйц	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>9,112.4</b>	<b>8,474.9</b>	<b>7,809.4</b>	<b>-665.5</b>	<b>92.1</b>	<b>-1,303.0</b>
Тогтворжуулалтын сан	94.6	55.2	66.2	11.0	119.9	-28.4
Ирээдүйн өв сан	1,040.2	943.2	914.1	-29.1	96.9	-126.1
<b>Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж</b>	<b>7,977.6</b>	<b>7,476.5</b>	<b>6,829.1</b>	<b>-647.4</b>	<b>91.3</b>	<b>-1,148.5</b>
<b>Үүнээс:</b>						-
Татварын орлого	6,493.5	6,095.9	5,690.2	-405.7	93.3	-803.3
Татварын бус орлого	1,484.1	1,380.6	1,138.9	-241.7	82.5	-345.2

3.1.2 Өмнөх оноос төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 1,148.5 тэрбум, Ирээдүйн өв сангийн хуримтлал 126.1 тэрбум, Тогтворжуулалтын сангийн хуримтлал 28.4 тэрбум төгрөгөөр буурчээ.

3.1.3 Тайлант оны улсын төсвийн нийт орлого ба тусламжийн 72.9 хувийг татварын, 14.6 хувийг татварын бус, 11.7 хувийг Ирээдүйн өв сангийн, 0.8 хувийг Тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.

3.1.4 Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 83.3 хувийг татварын, 16.7 хувийг татварын бус орлого тус тус бүрдүүлсэн бөгөөд татварын орлого өмнөх оноос 12.4 хувиар буюу 803.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

3.1.5 Орлогын төлөвлөгөөний биелэлтэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Үүнд: ДНБ 5.3 хувиар буурсан, ААН-үүдийн ажлын байрыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт 330.3 тэрбум, эдийн засгийг идэвхжүүлэхэд авч хэрэгжүүлсэн гадаад үйл ажиллагааны гааль, НӨАТ-ын чөлөөлөлт 45.5 тэрбум, татварын бус орлого 241.8 тэрбум төгрөгөөр тасарсан, НӨАТ-ын урамшууллын системийн цахим төлбөрийн баримтын тоо 585.6 саяд хүрч өмнөх оноос 26.2 хувиар өссөн боловч, ногдолтой тайлангийн тоо 27,784-өөр буурсан.

3.1.6 Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 183.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Үүнд: /Улаанбаатар 167.1 тэрбум, Өмнөговь 15.4 тэрбум, Дорноговь аймаг 1.1 тэрбум төгрөг/

3.1.7 **Улсын төсвийн татварын орлогын** 38.8 хувийг НӨАТ, 24.6 хувийг ААНОАТ, 13.7 хувийг ОАТ, 13.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 0.3 хувийг тусгай зориулалтын орлогын албан татвар, 9.6 хувийг бусад татвар (төлбөр хураамж)-аас бүрдүүлсэн байна.

3.1.8 **ААНОАТ-ын орлого** 1,398.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 338.0 тэрбум төгрөгөөр дутуу, өмнөх оноос 262.1 тэрбум төгрөгөөр буурсан нь эдийн засаг агшиж, хил гаалийн хүчин чадал удааширч, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч томоохон аж ахуйн нэгжүүдийн олборлолт, борлуулалтын орлогын бууралт нөлөөлжээ.

3.1.9 **НӨАТ-ын орлого** 2,209.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 69.0 тэрбум төгрөгөөр дутуу, өмнөх оноос 277.3 тэрбум төгрөгөөр буурсан нь импортын 1,287.8 тэрбум төгрөгийн бууралт, албан татварыг чөлөөлөх хуулийн зохицуулалт зэргээс шалтгаалжээ.

3.1.10 **Онцгой албан татварын орлого** 776.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 42.0 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 86.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд цар тахлын улмаас хөл хорио тогтоож, суудлын автомашин болон автобензин, дизель түлшний импортын онцгой албан татвар болон дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ буурсан нь нөлөөлжээ.

3.1.11 **Тусгай зориулалтын орлого:** Улсын төсөвт автобинзен, дизель түлшний албан татварт 17.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 107.0 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 0.8 тэрбум төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

3.1.12 **Гадаад үйл ажиллагааны орлого** 740.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 30.2 тэрбум төгрөгөөр тасарч, өмнөх оноос 49.5 тэрбум төгрөгөөр буурсан нь гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оноос 6.7 хувь, үүнд импорт 7.9 хувь, экспорт 1.0 хувь, татвартай импорт

9.2 хувиар буурч төгрөгийн ам.доллартой харьцах харьцаа дунджаар 4.9 хувиар суларснаас шалтгаалжээ.

3.1.13 Бусад татвар (төлбөр хураамж)-ын орлого 548.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 11.6 тэрбум, өмнөх оноос 128.7 тэрбум төгрөгөөр буурчээ.

3.1.14 Улсын төсвийн татварын бус орлого 1,138.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 17.5 хувиар буюу 241.7 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй, өмнөх оноос 23.3 хувиар буюу 345.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.1.15 Төсөвт байгууллагууд өөрийн орлогыг 55.5 тэрбум, орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 183.6 тэрбум, улсын төсвөөс НДС-д олгох татаас 54.5 тэрбум төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлжээ.

3.1.16 Хувьцааны ногдол ашгийн орлого ТӨБЗГ хувьцааны ногдол ашгийн орлого 1.0 тэрбум төгрөг дутуу төвлөрүүлсэн байна

Үүнд: “УБ Төмөр зам” ХНН 0.6 тэрбум, “ХАА-н бирж” ХХК 0.3 тэрбум, “Монголын төмөр зам” ТӨХК 89.3 сая, “Дарханы дулааны цахилгаан” ТӨХК 31.3 сая, “Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв” ТӨҮГ 19.2 сая төгрөг.

3.1.17 Газрын тосны орлого 110.0 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 7.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь дэлхийн зах зээл дээрх түүхий тосны үнэ, 1 баррелл тутмын ам.долларын ханш буурснаас голлон шалтгаалжээ.

3.1.18 Навигацийн орлогоор 75.0 тэрбум төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөө 100 хувийн биелэлттэй байна.

3.1.19 Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 232.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, төлөвлөснөөс 45.9 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байгаа нь дараах ТЕЗ-ын харьяа байгууллагуудын орлого 54.8 тэрбум төгрөгөөр тасарснаас голлон шалтгаалжээ.

Үүнд: ХХААХҮС 40.2 тэрбум, ЗТХС 6.3 тэрбум, ХНХС 2.0 тэрбум, ЭМС 2.1 тэрбум, БХС 0.9 тэрбум, ГХС 1.4 тэрбум, МУЕС 0.5 тэрбум, УУХҮС 0.8 тэрбум, Сангийн сайд 0.5 тэрбум, БШУС 0.1 тэрбум төгрөг.

3.1.20 Тусламжийн орлогын эх үүсвэрээр тайлант онд нийт 35 төсөл, арга хэмжээнд 150.3 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 27 нь хэрэгжиж, 161.6 тэрбум төгрөгийн ашиглалт гарсан байна. Үүнээс Ковид-19 тусламжийн хүрээнд 7.1 тэрбум төгрөгийн 3 төсөл, хөтөлбөрийн санхүүжилт авчээ.

### **Татварын зарлага**

3.1.21 Тайлант онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 906.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 73.6 хувь буюу 384.4 тэрбум төгрөгөөр өсөж татварын нийт орлогын 10.7 хувьтай тэнцсэн нь цар тахлын үед авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлтүүдээс шалтгаалсан байна.

## Хүснэгт 15 Татварын зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Байгууллага	Хамрагдсан иргэн, ААН	2019 он	2020 он	Зөрүү	Хувь
Татварын орлого		<b>9,813.2</b>	<b>8,511.6</b>	<b>-1,301.6</b>	<b>-13.3</b>
Нийт татварын зарлага		<b>522.3</b>	<b>906.8</b>	<b>384.5</b>	<b>73.6</b>
Татварын зарлагын эзлэх хувь		5.3	10.7	5.4	0.0
Татварын байгууллага	<b>428,802</b>	<b>307.5</b>	<b>703.8</b>	<b>396.3</b>	<b>77.6</b>
ААНОАТ	17,902	53.8	201.5	147.7	22.2
ХХОАТ	407,916	178.6	386.9	208.3	42.7
НӨАТ	2,984	75.1	115.4	40.3	12.7
Гаалийн байгууллага	<b>5,324</b>	<b>214.8</b>	<b>203.0</b>	<b>-11.9</b>	<b>22.4</b>
Гаалийн татвар	992	27.5	30.8	3.3	3.4
ОАТ	3,230	125.1	104.0	-21.1	11.5
НӨАТ	1,102	62.2	68.1	5.9	7.5

3.1.22 Иргэдийн орлогыг хамгаалах, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр дараах төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.

Үүнд:

- Хувийн хэвшилд ажиллаж буй иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгах ХХОАТ 209.4 тэрбум;
- Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогын албан татвараас 116.9 тэрбум;
- Түрээсийн төлбөр бууруулсан аж ахуйн нэгжүүдийн 2.3 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулсан ургамлын тос, дотоодод борлуулсан мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, бүх төрлийн хүнсний будааг /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/ 1.7 тэрбум;
- Хүнсний гол нэр төрлийн бараа 31.2 тэрбум, цар тахлын эсрэг нэн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл 14.3 тэрбум, нийт 45.5 тэрбум төгрөгийн гаалийн болон НӨАТ-ыг чөлөөлсөн байна.

## 3.2 Улсын төсвийн зарлага

3.2.1 Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар нийт зарлага ба цэвэр зээлийг 11,653.3 тэрбум төгрөгөөр баталж, өмнөх оны гүйцэтгэлээс 2,358.2 тэрбум төгрөг буюу 25.4 хувиар нэмэгдүүлсэн байна.

3.2.2 Зарим ТЕЗ-д төсвийн саналаа төсвийн хязгаараас 5,142.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн, хөтөлбөр, арга хэмжээний тооцоолол, үндэслэл, тайлбар хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуультай<sup>17</sup> нийцэхгүй байна.

Тухайлбал:

БШУС 2,657.4 тэрбум, ХНХС 857.6 тэрбум, БХБС 540.3 тэрбум, Соёлын сайд 538.3 тэрбум, ХЗДХС 493.1 тэрбум, ХХААХҮС 351.3 тэрбум, БОАЖС 311.1 тэрбум төгрөг.

3.2.3 Тайлант онд улсын төсвийн зарлага 10,735.6 тэрбум төгрөг буюу 92.1 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 917.6 тэрбум төгрөгийг дутуу зарцуулсан байна.

## Хүснэгт 16 Монгол Улсын 2020 оны төсвийн зарлагын эдийн засгийн ангилал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он гүйц	2020 он				Дүнд эзлэх хувь
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>9,295.1</b>	<b>11,653.3</b>	<b>10,735.6</b>	<b>92.1</b>	<b>-917.6</b>	<b>100.0</b>
<b>А. Урсгал зарлага</b>	<b>6,353.5</b>	<b>8,806.1</b>	<b>8,224.8</b>	<b>93.4</b>	<b>-581.1</b>	<b>76.6</b>
Бараа, үйлчилгээний зардал	2,359.5	3,147.0	2,921.9	92.8	-225.1	27.2
Хүү	861.0	972.6	932.8	95.9	-39.8	8.7
Татаас ба урсгал шилжүүлэг	3,133.0	4,686.5	4,370.1	93.2	-316.4	40.7
<b>Б. Хөрөнгийн зардал</b>	<b>2,548.2</b>	<b>2,828.5</b>	<b>2,487.5</b>	<b>87.9</b>	<b>-341.0</b>	<b>23.2</b>
<b>В. Эргэж төлөгдөх цэвэр зээл</b>	<b>393.4</b>	<b>18.6</b>	<b>23.3</b>	<b>125.3</b>	<b>4.7</b>	<b>0.2</b>

3.2.4 Улсын төсвийн хөрөнгийн зардал өмнөх оноос 60.7 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл 370.1 тэрбум төгрөгөөр буурч, урсгал зарлага 1,871.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

<sup>17</sup> Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах, 31 дүгээр зүйлийн 31.2-т Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 31.1.3-т заасан хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ

Урсгал шилжүүлгийн өсөлт дараах шалтгаантай байна.

Тухайлбал:

- ХНХС: Цар тахалтай холбоотой халамжийн сангийн зарим үйлчилгээнд олгох мөнгөн дүнг нэмэгдүүлснээс 893.6 тэрбум;
- ХХААХҮС: Малчин, мал бүхий иргэдэд олгох ноолуурын урамшуулалд 175.0 тэрбум;
- БШУС: Тайлант онд улсын хэмжээнд нийт 30 сургууль, 64 цэцэрлэг, 12 спорт заал, 22 дотуур байрны барилга ашиглалтад орсон, мөн сургууль цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо 5-8 хувиар өссөнтэй холбоотой тусгай зориулалтын шилжүүлэгт 139.0 тэрбум;
- Сангийн сайд: Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгт 40.7 тэрбум, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 100.0 хувь төвлөрүүлдэг болсонтой холбоотой 15.0 тэрбум;
- ЭМС: Цар тахалтай тэмцэх, сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд дайчлагдан ажилласан, халдвар авсан ажилтнуудад олгох санхүүгийн дэмжлэгт 2.2 тэрбум, анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд олгох мөнгөн тэтгэмжид 2.3 тэрбум, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын үндсэн цалинг 8.0 хувиар нэмсэн, нэг иргэнд ногдох тусламж үйлчилгээний зардлын зориулалтын шилжүүлэгт 29.8 тэрбум, нийт 34.3 тэрбум төгрөгийг олгосонтой холбоотой байна.

3.2.5 Бараа үйлчилгээний зардал өмнөх онтой харьцуулахад 562.4 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 193.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосонтой<sup>18</sup> холбоотой байна.

3.2.6 Тайлант онд цалингийн зардал 1,400.2 тэрбум төгрөг буюу 97.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарим ТЕЗ-д цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг илүү тооцож олгосон, цалингийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлын ангилалд төлөвлөж зарцуулсан дараах зөрчлүүд гарчээ.

Тухайлбал:

- Цалингийн зардлаас 1.2 тэрбум төгрөгийн шагнал, урамшуулал хавтгайруулан олгосон /УУХҮС 0.4 тэрбум, БШУС 0.3 тэрбум, ЗТХС 0.2 тэрбум, Шадар сайд 0.1 тэрбум төгрөг/
- Цалинг зөрүүтэй тооцсон, сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон нийт 2.5 тэрбум төгрөг /ЭМС 2.4 тэрбум, БШУС 0.1 тэрбум төгрөг/

3.2.7 Зарим ТЕЗ-дын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд байна.

Тухайлбал:

- Зардлын төлөвлөлттэй холбоотой 13.3 тэрбум төгрөг /Соёлын сайд 10.0 тэрбум, ЭМС 2.3 тэрбум, ГХС 1.0 тэрбум/
- Зориулалт бусаар зарцуулсан 3.3 тэрбум төгрөг /УУХҮС 1.0 тэрбум, ЗТХС 0.9 тэрбум, МУШС 0.5 тэрбум, ХЗДХС 0.3 тэрбум, Соёлын сайд 0.2 тэрбум, ЭМС 0.2 тэрбум, МУЕП 0.1 тэрбум, СЗХ 0.1 тэрбум төгрөг/;
- Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн 9.5 тэрбум төгрөг./ЭМС 6.5 тэрбум, БШУС 1.9 тэрбум УУХҮС 0.6 тэрбум, ЗГХЭГ 0.3 тэрбум, МУШС 0.2 тэрбум/

3.2.8 Төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан 30 байгууллагын 38 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 0.6 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосон боловч, шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудаар төлүүлээгүй байна.

3.2.9 Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын<sup>19</sup> дагуу 10 ТЕЗ-ийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 53 төсөл арга хэмжээний санхүүжилт 50.4 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нь нийт хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг 2.1 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

3.2.10 Тайлант онд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр 1,174.2 тэрбум төгрөгийн 93 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,072.9 тэрбум төгрөгийн 72 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 91.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

<sup>18</sup> Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолоор

<sup>19</sup> Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "... төсвийн зарцуулагдаагүй үлдээдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолоор баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1.1-д "... төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах"

3.2.11 Тайлант онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 972.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 932.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс, гадаад өрийн хүүгийн төлбөрт 775.7 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 157.1 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

### 3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, үр дүн

3.3.1 Засгийн газраас 2019 онд баримталсан эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 56 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 158 хөтөлбөр 1004 арга хэмжээнд 14,577.5 тэрбум төгрөгийг төлөвлөжээ.

3.3.2 Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д 32 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 93 хөтөлбөрийн хүрээнд 385 арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг баталжээ.

3.3.3 Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Засаг даргын хэрэгжүүлэх 65 хөтөлбөрийн хүрээнд 619 арга хэмжээ баталсан байна.

3.3.4 ТЕЗ-д жилийн төсвийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл<sup>20</sup>, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй<sup>21</sup> уялдуулалгүйгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хөтөлбөрт хүрэх үр дүнг хэт ерөнхий байдлаар тусгажээ.

3.3.5 Төсвийн төсөл бэлтгэх удирдамжид төсвийг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанар болон тоо хэмжээний үзүүлэлтийг тооцох, үнэлэх, шалгуур үзүүлэлтийг тогтоох аргачлалыг тодорхой тусгах шаардлагатай байна.

3.3.6 Монгол Улсын 2020 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг анх батлагдсан төсвөөс 801.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 11,653.3 тэрбум төгрөгөөр баталсан боловч ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрт хүрэх үр дүн, чанар тоо хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байна.

3.3.7 Улсын ТЕЗ-дын 5 арга хэмжээ хэрэгжээгүй, Худалдааг хөнгөвчилж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг 5 хувиар бууруулах, Гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийг 5 хувиар нэмэгдүүлэх 2 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

3.3.8 Зарим ТЕЗ-д хөтөлбөрийн хүрэх түвшин хэт ерөнхий, хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан, төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, үр дүнгийн танилцуулгыг бэлтгээгүй байна.

### 3.4 Улсын төсвийн тэнцэл

3.4.1 Тайлант онд улсын төсвийн нийт тэнцлийг 4,176.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 3,906.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 3.0 дахин өссөн байна.

3.4.2 Улсын төсвийн дутагдлыг нөхөхөд зориулж хөтөлбөрийн зээлээс 1,978.1 тэрбум, төслийн зээлийн ашиглалтад 1,374.4 тэрбум төгрөг авч, гадаад өрийн зохицуулалт хийх зорилгоор 1,692.6 тэрбум төгрөгийн Номад бонд гаргаж, Тогтворжуулалтын сангаас 138.8 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлого 0.4 тэрбум төгрөг, нийт 5,184.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

3.4.3 Дээрх эх үүсвэрүүдээс дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд 263.0 тэрбум, гадаад зээлийн үндсэн төлбөрт 691.1 тэрбум, гадаад бондын эргэн төлөлтөд 1,679.0 тэрбум, харилцах болон хадгаламжийн дансны эхний үлдэгдлээс 1,355.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулан нийт 3,906.6 тэрбум төгрөгийн төсвийн алдагдлыг санхүүжүүлжээ.

<sup>20</sup> Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан.

<sup>21</sup> Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан.

## IV БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН 2020 ОНЫ ТӨСӨВ

## 4.1 Орон нутгийн төсвийн орлого

4.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийг 3,311.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 5.0 хувиар буюу 164.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрч, өмнөх оноос 199.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

4.1.2 Нийт орлого ба тусламжийн орлогын 39.3 хувийг татварын, 60.7 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

## Хүснэгт 17 Орон нутгийн 2020 оны төсвийн орлого /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он		2020 он		
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	<b>2,947.6</b>	<b>3,311.7</b>	<b>3,146.8</b>	<b>95.0</b>	<b>-164.9</b>
Татварын орлого	<b>1,289.2</b>	<b>1,287.6</b>	<b>1,235.5</b>	<b>95.9</b>	<b>-52.1</b>
Орлогын албан татвар	895.2	827.9	828.9	100.1	1.0
Хөрөнгийн албан татвар	154.3	175.3	154.9	88.4	-20.4
Бусад татвар төлбөр хураамж	239.7	284.4	251.7	88.5	-32.7
Татварын бус орлого	<b>1,658.4</b>	<b>2,024.1</b>	<b>1,911.3</b>	<b>94.4</b>	<b>-112.8</b>
Нийтлэг бус татварын орлого	209.3	219.9	197.1	89.6	-22.8
Хөрөнгийн орлого	0.8	1.5	1.2	80.0	-0.3
Тусламж/ Шилжүүлэг	1,448.3	1,802.7	1,713.0	95.0	-89.7

4.1.3 Дутуу төвлөрүүлсэн 164.9 тэрбум төгрөгийн 68.4 хувийг татварын бус орлого, 31.6 хувийг татварын орлого эзэлж байна.

4.1.4 Татварын орлогын 828.9 тэрбум төгрөгийг орлогын албан татвар, 154.9 тэрбум төгрөгийг хөрөнгийн албан татвар, 251.7 тэрбум төгрөгийг бусад татвар хураамж бүрдүүлсэн байна.

4.1.5 Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Хэнтий аймгаас бусад 17 аймгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

## Хүснэгт 18 Орон нутгийн 2020 оны нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	81.2	82.0	101.0	0.8	Орхон	130.7	136.1	104.1	5.4
Баян-Өлгий	95.7	88.5	92.5	-7.2	Өвөрхангай	99.1	97.1	98.0	-2.0
Баянхонгор	90.3	88.7	98.2	-1.6	Өмнөговь	188.3	175.9	93.4	-12.4
Булган	68.7	67.0	97.5	-1.7	Сүхбаатар	70.2	67.6	96.3	-2.6
Говь-Алтай	70.8	69.7	98.4	-1.1	Сэлэнгэ	101.3	97.5	96.2	-3.8
Говьсүмбэр	18.5	18.7	101.1	0.2	Төв	97.8	94.8	96.9	-3.0
Дархан-Уул	74.9	75.5	100.8	0.6	Увс	93.3	90.9	97.4	-2.4
Дорноговь	90.0	81.5	90.6	-8.5	Улаанбаатар	1,447.0	1,326.8	91.7	-120.2
Дорнод	74.0	73.3	99.1	-0.7	Ховд	86.3	84.2	97.6	-2.1
Дундговь	53.8	53.1	98.7	-0.7	Хөвсгөл	118.3	116.6	98.6	-1.7
Завхан	80.1	78.9	98.5	-1.2	Хэнтий	81.4	82.4	101.2	1.0
<b>Нийт дүн</b>						<b>3,311.7</b>	<b>3,146.8</b>	<b>95.0</b>	<b>-164.9</b>

4.1.6 Татварын орлогыг 20 аймаг 43.5 тэрбум төгрөгөөр давуулж, Улаанбаатар 91.4 тэрбум, Дорноговь аймаг 4.2 тэрбум төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

4.1.7 Өмч хувьчлалын орлого 65.5 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.2 тэрбум, Өмнөговь аймгийн татварын бус орлого 14.4 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

4.1.8 Тайлант онд Улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг 201.7 тэрбум, ОНХС-ийн шилжүүлэг 165.7 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлгээр 1,333.9 тэрбум, ЭМДС-аас 7.3 тэрбум, нийт 1,708.6 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд орон нутгийн суурь орлого 1,438.2 тэрбум төгрөг байна.

4.1.9 Орон нутгийн төсвийн суурь зардалд санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь өмнөх оноос 1.5 нэгжээр өсөж 24.2 хувьд хүрсэн байна.

## 4.2 Орон нутгийн төсвийн зарлага

4.2.1 Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 3,157.2 тэрбум төгрөг буюу 84.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

## Хүснэгт 19 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 он гүйц	2020 он			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,927.7	3,717.9	3,157.2	84.9	-560.7
А. Урсгал зардал	2,436.2	2,996.7	2,592.6	86.5	-404.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,847.8	2,357.3	2,171.2	92.1	-186.1
Хүү	-	6.4	6.4	100.0	-
Татаас	158.1	173.7	168.6	97.1	-5.1
Урсгал шилжүүлэг	430.3	459.3	246.4	53.6	-212.9
Б. Хөрөнгийн зардал	468.5	685.5	546.8	79.8	-138.7
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	23.0	35.7	17.8	49.8	-17.9

4.2.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 82.1 хувийг урсгал, 17.3 хувийг хөрөнгийн, 0.6 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

4.2.3 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл өмнөх оноос 5.2 тэрбум төгрөгөөр буурч, хөрөнгийн зардал 78.3 тэрбум, урсгал зардал 156.4 тэрбум төгрөгөөр буюу нийт зардал 7.8 хувиар өссөн байна.

## Хүснэгт 20 Аймаг, нийслэлийн 2020 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээл /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Зарлага				Аймаг, нийслэл	Зарлага			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	84.9	79.3	93.4	-5.6	Орхон	154.1	132.5	86.0	-21.6
Баян-Өлгий	96.5	88.4	91.7	-8.1	Өвөрхангай	105.2	96.5	91.7	-8.7
Баянхонгор	94.2	87.3	92.6	-6.9	Өмнөговь	236.1	200.7	85.0	-35.4
Булган	71.7	64.1	89.4	-7.6	Сүхбаатар	73.2	66.0	90.1	-7.2
Говь-Алтай	72.8	64.8	89.0	-8.0	Сэлэнгэ	104.6	91.6	87.6	-13.0
Говьсүмбэр	20.6	18.7	91.0	-1.9	Төв	105.2	92.5	87.9	-12.7
Дархан-Уул	78.2	72.7	92.9	-5.5	Увс	96.2	89.4	93.0	-6.8
Дорноговь	93.4	82.6	88.4	-10.8	Улаанбаатар	1,709.3	1,357.2	79.4	-352.1
Дорнод	78.1	71.9	92.0	-6.2	Ховд	91.6	84.1	91.9	-7.5
Дундговь	58.1	49.6	85.4	-8.5	Хөвсгөл	122.7	113.6	92.6	-9.1
Завхан	84.0	76.5	91.0	-7.5	Хэнтий	87.2	77.2	88.5	-10.0
<b>Нийт дүн</b>						<b>3,717.9</b>	<b>3,157.2</b>	<b>84.9</b>	<b>- 560.7</b>

4.2.4 Тайлант онд УИХ, Засгийн газрын холбогдох тогтоолыг үндэслэн төсөвт 2-3 удаа зохицуулалт хийсэн байна.

4.2.5 Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллага төсвийн сахилга бат, дотоод хяналт сул байгаагаас 5.8 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Хөвсгөл аймаг эдийн засгийн ангилал зөрчиж 1.8 тэрбум, улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэсэн 0.8 тэрбум;
- Дорноговь аймаг зураг төсөв батлагдаагүй хөрөнгө оруулалтад 1.3 тэрбум;
- Баяр ёслол уралдаан тэмцээн зохион байгуулах, сонин, хэвлэл, үйл ажиллагааг сурталчлах, уран сайхны гэрэл зураг, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ээр видео шторк хийлгүүлсэн зэрэгт 1.9 тэрбум төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан /Нийслэл 1.6 тэрбум, Дундговь 0.2 тэрбум, Архангай 0.1 тэрбум төгрөг/

4.2.6 СХС-ийн зээлийн эргэн төлөлтөд 34.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12.1 тэрбум төгрөг төвлөрч сангаас санхүүжигдэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт хангагдаагүй байна.

4.2.7 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын орон тоог 107,919 байхаар баталж, гүйцэтгэлээр 1,436 орон тоо дутуу боловч 7 аймаг батлагдсанаас 520 орон тоо хэтрүүлсэн байна. /Баян-Өлгий аймаг 275, Дархан-Уул аймаг 98, Орхон 49, Баянхонгор аймаг 40, Увс аймаг 34, Архангай аймаг 12, Говь-сүмбэр 12/

4.2.8 Албан тушаалтны буруутай үйлдлээс хууль бусаар ажлаас халагдсан 90 ажилтанд Шүүхийн шийдвэрээр 0.6 тэрбум төгрөгийн тэтгэмжийг<sup>22</sup> олгохдоо буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

<sup>22</sup> Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.

4.2.9 Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой 4.3 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрчээ.

Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, орлогын төлөвлөгөөг хэт багаар төлөвлөсөн, зураг, төсөв батлагдаагүй төсөл арга хэмжээ санхүүжүүлсэн. /Архангай аймаг 0.1 тэрбум, Өмнөговь аймаг 1.9 тэрбум, Дорноговь 2.3 тэрбум/

#### **4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл**

4.3.1 Төсвийн нийт тэнцлийг 406.2 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 10.4 тэрбум төгрөг гарч, өмч хувьчлалын орлогоос санхүүжүүлсэн байна.

4.3.2 Урд оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс Нийслэл 30.4 тэрбум, Өмнөговь аймаг 24.8 тэрбум, Дорноговь аймаг 1.1 тэрбум төгрөгийг зарцуулж, алдагдалтай ажилласан байна.

## V БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

## 5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого

5.1.1 НДС-ийн төсвийн тухай хуулиар орлогыг 1,812.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,878.2 тэрбум төгрөг буюу 103.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 21 НДС-ийн 2020 оны орлого /тэрбум төгрөг/

Орлогын төрөл	2019 он		2020 он		
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Тэтгэвэр	1,469.5	1,161.0	1,198.4	103.2	37.4
Тэтгэмж	157.5	97.8	111.3	113.8	13.5
ҮОМШӨ	211.0	127.3	142.1	111.6	14.8
Ажилгүйдлийн	41.5	25.6	25.9	101.2	0.3
УТ-ийн дэмжлэг	605.5	399.4	399.4	100.0	-
ЭМДС-аас олгох шилжүүлэг	-	1.1	1.1	100.0	-
<b>Нийт дүн</b>	<b>2,485.0</b>	<b>1,812.2</b>	<b>1,878.2</b>	<b>103.6</b>	<b>66.0</b>

5.1.2 НДС-ийн нийт орлого өмнөх оноос 606.8 тэрбум төгрөгөөр буурсан нь цар тахлын үед ажлын байрыг хадгалах чиглэлийн дагуу албан журмын болон сайн дурын даатгуулагчдаас төлөх нийт 642.6 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 206.1 тэрбум төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

5.1.3 Тайлант онд нийт орлого 66.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оноос 2.2 хувь буюу 1.1 мянгаар, сайн дурын даатгуулагчдын тоо 2.9 хувь буюу 5.4 мянгаар өссөнтэй холбоотой байна.

5.1.4 Тайлант онд 57.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оноос 29.7 тэрбум төгрөгөөр буурсан нь арилжааны банканд 694.7 тэрбум төгрөгийг 6 хувийн хөнгөлөлттэй хүүтэй<sup>23</sup> байршуулсантай холбоотой байна.

5.1.5 НДЕГ Чингис хаан банкттай холбоотой шүүхэд нэхэмжлэл гаргасан ба шүүхийн захирамжийн дагуу 2.6 тэрбум төгрөгийн<sup>24</sup> хүүгийн орлого олох боломжийг алдсан байна.

5.1.6 Арилжааны банкин дахь туслах үйл ажиллагааны орлого 0.3 тэрбум төгрөгийг төвлөрсөн санд төвлөрүүлээгүй байна.

5.1.7 Сангийн сайд, ХНХС-ын 2018 оны хамтарсан 126/А/130 дугаар тушаалаар 2003 оны 45/21 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журам”-ыг хүчингүй болгосноор НДС-ийн төлбөр тооцоог зохицуулах эрх зүйн баримт бичиг тодорхойгүй байна.

## 5.2 Нийгмийн даатгалын сангийн зарлага

5.2.1 Нийт зарлагын хэмжээг 2,494.0 тэрбум төгрөгөөр баталснаас 2,451.8 тэрбум төгрөг буюу 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 22 НДС-ийн 2020 оны зарлага /тэрбум төгрөг/

Даатгалын сангийн төрөл	2019 он		2020 он		
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Тэтгэвэр	1,839.2	2,173.0	2,153.6	-19.4	99.1
Тэтгэмж	124.2	143.7	145.4	1.7	101.2
ҮОМШӨ	30.8	35.0	31.6	-3.4	90.3
Ажилгүйдлийн	43.6	115.1	94.4	-20.7	82.0
ҮА-ны зардал	24.5	27.2	26.8	-0.4	98.5
<b>Нийт дүн</b>	<b>2,062.3</b>	<b>2,494.0</b>	<b>2,451.8</b>	<b>-42.2</b>	<b>98.3</b>

5.2.2 Нийт зарлага өмнөх оноос 389.5 тэрбум төгрөгөөр өсөхөд 426.5 мянган тэтгэвэр авагчдын тэтгэврийг дунджаар 8.0 хувиар нэмснээс 150.0 тэрбум, тэтгэвэр авагчдын тоо 5.8 хувиар буюу 24.1 мянгаар өссөн, ажилгүйдлийн даатгалын сангаас 44.1 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн дэмжлэг олгосон<sup>25</sup>, эхчүүдэд ЖАТ-ийг

100 хувиар тооцон 10.1 тэрбум төгрөгийг олгосон нь голлон нөлөөлсөн байна.

5.2.3 Үйл ажиллагааны зардал 27.2 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 26.8 тэрбум төгрөг буюу 98.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, орон тооны хэмнэлтээс үндсэн цалинг 0.2 тэрбум, хангамж

<sup>23</sup> Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйл "... үнэт цаасыг банк эзэмших хугацаанд нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгөөс хөнгөлөлттэй хүүтэй хадгаламж байршуулж болно.", Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар тогтоолоор хүүгийн хэмжээг 6 хувиар баталсан.

<sup>24</sup> Сүхбаатар дүүргийн шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181/ШШ2020/02624 дугаар захирамж

<sup>25</sup> Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйл "... даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно."

бараа материал, томиллолт, эд хогшил, урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн дадлага зэрэг зардлууд 0.2 тэрбум төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

### 5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

5.3.1 НДС-ийн төсвийн тэнцлийг 681.8 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 573.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

## VI БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

### 6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

6.1.1 Нийт орлогыг 506.5 тэрбум төгрөгөөр баталснаас, 476.5 тэрбум төгрөг гарч, 94.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 23 ЭМДС-ийн орлого /тэрбум төгрөг/

Шимтгэл Төрөл	2019 он гүйц	2020 он			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Ажил олгогч	123.4	133.6	133.6	100.0	-
Даатгуулагч	150.4	158.2	141.0	89.1	-17.2
Төсөвт байгууллага	54.5	53.6	48.2	89.9	-5.4
Төр даатгалыг нь хариуцах иргэдийн	83.8	84.1	84.0	99.9	-0.1
Бусад даатгуулагч	14.8	19.4	14.7	75.8	-4.7
Бусад орлого	42.7	57.6	55.0	95.5	-2.6
<b>Нийт дүн</b>	<b>469.6</b>	<b>506.5</b>	<b>476.5</b>	<b>94.1</b>	<b>-30.0</b>

6.1.2 Нийт орлогын 67.7 хувийг аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын ажил олгогч, даатгуулагч, 17.6 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэд, 3.1 хувийг бусад даатгуулагчийн төлөх шимтгэл, 11.5 хувийг бусад орлого бүрдүүлж байна. Эрүүл мэндийн даатгалд 3,257.8 мянган даатгуулагч хамрагдаж өмнөх оноос 11.5 хувиар нэмэгдсэн байна.

### 6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага

6.2.1 Нийт зарлагыг 494.5 тэрбум төгрөгөөр баталснаас 426.4 тэрбум төгрөг гарч, 86.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 24 ЭМДС-ийн зарлага /тэрбум төгрөг/

Зардлын төрөл	2019 он гүйц	2020 он			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Төрийн өмчийн ЭМБ	236.8	291.3	268.3	92.1	-23.0
Хувийн эмнэлэг, эмийн сан	105.3	167.7	135.1	80.5	-32.6
Сум тосгоны ЭМТ	4.0	8.7	7.2	82.4	-1.5
ҮА-ны зардал	4.6	6.5	5.9	90.2	-0.6
Буцаан олголт	0.3	0.2	0.2	85.0	-
Эрсдэлийн сан		20.0	9.6	48.0	-10.4
<b>Нийт дүн</b>	<b>351.0</b>	<b>494.5</b>	<b>426.4</b>	<b>86.2</b>	<b>-68.1</b>

6.2.2 Тайлант онд давхардсан тоогоор 9.8 сая даатгуулагчдын тусламж, үйлчилгээний зардалд 418.6 тэрбум төгрөгийг 2000 гаруй эрүүл мэндийн байгууллагад олгожээ.

6.2.3 “Цахим жор” программ хангамжийг нэвтрүүлснээр эмийн сангуудаар олгох хөнгөлөлттэй эмийн зардалд тавих хяналт сайжирч 7.3 тэрбум төгрөг хэмнэсэн,

хувийн эмнэлэг, эмийн санд олгох тусламж үйлчилгээний зардал 32.6 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

6.2.4 Цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагууд бүрэн хүчин чадлаараа ажиллаагүйгээс хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад олгох санхүүжилт 25.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан.

Үүнд:

- Хувийн эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг 19.1 тэрбум,
- Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд эмийн хөнгөлөлт, шинжилгээ 3.5 тэрбум,
- ӨЭМТ-үүдэд олгох санхүүжилт 2.7 тэрбум төгрөг.

6.2.5 Тайлант онд ЭМД-ийн эрсдэлийн сангаас холбогдох журмын<sup>26</sup> заалтыг үндэслэн 16 аймаг, 2 дүүрэгт "Хүчил төрөгчийн бэсрэг үйлдвэрийн баллон" барих ажилд зарцуулахаар хөрөнгө оруулалтын дансанд 9.6 тэрбум төгрөгийг байршуулжээ.

ЭМДҮЗ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолоор ЭМД-ын эрсдэлийн сангийн хөрөнгийг 20.5 тэрбум төгрөгөөр бүрдүүлсэн байна.

6.2.6 Эрүүл мэндийн даатгалын иргэд рүү чиглэсэн төрийн үйлчилгээний хүрэлцээ, хүртээмж нэмэгдэж<sup>27</sup>, тайлант онд нийт 2779 эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулан ажиллажээ<sup>28</sup>.

### 6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

6.3.1 ЭМДС-ийн төсвийн тэнцлийг 12.0 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөснөөс 50.1 тэрбум төгрөгийн ашигтай гарч, мөнгөн хөрөнгө өссөн байна.

## VII БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1.1 Тайлант онд нэмэлт төсвөөр 919.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 294.4 тэрбум төгрөг буюу 47.1 хувиар өссөн байна. Нийт эх үүсвэрийн 75.4 хувийг улсын төсвөөс, 24.6 хувийг орон нутгийн төсвөөс бүрдүүлжээ.

7.1.2 Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах орлогоос бүрджээ.

Үүнд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 271.4 тэрбум,
- ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 133.5 тэрбум;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 174.3 тэрбум;
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 340.6 тэрбум төгрөг байна.

7.1.3 Хандив, тусламжийн орлого 174.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2.6 дахин өссөн нь Хүнс тэжээл, нийгмийн төсөл, Боловсролын чанарын шинэчлэл төслүүдээс хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний талон олгосон, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс албан журмын болон сайн дурын даатгуулагчийн НДШ-ийн чөлөөлөлтийг санхүүжүүлснээс шалтгаалжээ.

7.1.4 ТЕЗ-дын харьяа төсвийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 340.6 тэрбум төгрөг төвлөрснөөс Сангийн сайдын 2020 оны 225 дугаар тушаалаар давсан орлогоос 6.9 тэрбум төгрөгийг зарцуулах эрхийг олгосон байна.

7.1.5 Бараа, ажил үйлчилгээний зардалд 596.5 тэрбум, дотоод зээлийн хүүгийн зардалд 6.4 тэрбум, татаас, урсгал шилжүүлэгт 287.7 тэрбум, хөрөнгийн зардалд 59.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

7.1.6 Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-д зааснаас бусад орлогыг төвлөрүүлэн зарцуулсан, төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах эрхийг жилд 2 удаа нээж санхүүжүүлэхээр тусгасан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

<sup>26</sup> Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банканд хадгалуулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-т "Хүн амыг олноор хамарч удаан хугацааны эмчилгээ, зардал шаардагдах өвчин, халдварт цах тахлын тархалтыг таслан зогсооход шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эм, эмийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх";

<sup>27</sup> ЭМДЕГ-тай гэрээтэй эмийн сан 621, рашаан сувилал 1, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв 33, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багцын шинжилгээний лаборатори 2 нэмэгдсэн, шүдний эмнэлэг 14, элэгний В,С вирус тодорхойлох лаборатори 2, хувийн эмнэлэг 3 буурсан;

<sup>28</sup> Төрийн өмчийн-103 ЭМБ, хувийн хэвшлийн-2676 ЭМБ.

## VIII БҮЛЭГ. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

8.1.1 Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх багц арга хэмжээг УИХ-ын тогтоолоор<sup>29</sup> баталсан байна.

8.1.2 Засгийн газар тус тогтоолын хэрэгжилтийг хангаж цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээг 5,091.3 тэрбум (5.1 их наяд багц) төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хүснэгт 25 Цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээний төлөвлөгөө /тэрбум төгрөг/

Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт дүн	Эх үүсвэр		
			Төсвөөс	Гадаад зээл, тусламж	Бусад
I.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж	168.0	9.0	159.0	
	Ковид-19 зардал <sup>30</sup>	27.1	6.5	20.6	
	Цалин, урамшуулал <sup>31</sup>	1.5	1.5		
	Бусад арга хэмжээ	184.5	184.5		
	Хүүхдийн мөнгө	850.0	850.0		
	Халамжийн тэтгэвэр	20.0	20.0		
	Хүнсний талон	60.0	60.0		
	Ноолуурын урамшуулал	300.0	300.0		
II.Ажлын байрыг хадгалах	Вакцинжуулалт	118.6	118.6		
	Хөнгөлөлт, чөлөөлөлт <sup>32</sup>	-			
III.Эдийн засгийг идэвхжүүлэх	Ажилгүйдлийн тэтгэмж	-			
	Татварын чөлөөлөлт <sup>33</sup>	-			
	Төсвийн дэмжлэг <sup>34</sup>	3,100.0		3,100.0	
	Ногдол ашиг <sup>35</sup>	119.6			119.6
	Зээлийн батлан даалт <sup>36</sup>	108.0			108.0
	Тоног төхөөрөмжийн хөнгөлөлт <sup>37</sup>	34.0	34.0		
<b>Нийт дүн</b>		<b>5,091.3</b>	<b>1,584.1</b>	<b>3,279.6</b>	<b>227.6</b>

8.1.3 Цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээг иргэдийн эрүүл мэнд, орлого, ажлын байрыг хамгаалах, эдийн засгийг дэмжихдээ зарлагыг нэмэх, татварын орлогоос хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, төсвийн дутагдлыг хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээр бүрдүүлж, хэрэгжүүлсэн байна.

8.1.4 Цар тахлын эсрэг 5,091.3 тэрбум төгрөгийн багц арга хэмжээний хүрээнд төсвөөс 1,183.4 тэрбум төгрөгийг зарцуулж, гадаад зээл, тусламжаас 2,260.1 тэрбум төгрөгийн төсвийн дэмжлэг авсан байна.

Хүснэгт 26 Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн эдийн засгийн арга хэмжээ /тэрбум төгрөг/

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Нийт	Хэрэгжилт			
		Зардал	Авсан зээл, тусламж	Хөнгөлөлт, чөлөөлөлт	Бусад арга, хэмжээ
Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах	363.6	195.7	152.8		15.1
Иргэдийн орлогыг хамгаалах	1,158.0	943.6			214.4
Ажлын байрыг хадгалах	1,197.2	44.1	75.3	1,077.6	0.2
Эдийн засгийг идэвхжүүлэх	2,097.6		2,032.0	52.0	13.6
<b>Нийт дүн</b>	<b>4,816.4</b>	<b>1,183.4</b>	<b>2,260.1</b>	<b>1,129.6</b>	<b>243.3</b>

<sup>29</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай

<sup>30</sup> Эм, эмийн хэрэгсэл, онилуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл

<sup>31</sup> Халдварын голомтын бүсэд ажилласан тусгай албан хаагчдад цалин илүү цаг урамшууллын хоолны зардал

<sup>32</sup> ААНОАТ, НДШ, ХХОАТ, Сайн дурын даатгал, торгууль, алданги, түрээсийн орлогод ногдуулах албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

<sup>33</sup> Импортын барааны НӨАТ, Гаалийн албан татвараас чөлөөлөх

<sup>34</sup> Хөнгөлөлттэй зээл тусламжийн хямд эх үүсвэрийг ашиглана /ОУВС-ийн хөтөлбөр төсвийн дэмжлэг 60.0 сая ам.доллар, Европын холбооноос 47.1 тэрбум, шинээр авах төсвийн дэмжлэг 200.0 сая ам.доллар, бусад 100.0 сая ам.доллар, шинээр хэрэгжүүлэх төсөл 720.0 сая ам.доллар/

<sup>35</sup> Эрдэнэс таван толгой ХХК-ийн 1072 ширхэг хувьцааны 2019 оны ногдол ашиг олгоно /2.5 сая иргэн, 486 ААН-д/

<sup>36</sup> Барьцаа хөрөнгийн дутагдалтай ААН-ийн 300.0 сая төгрөг хүртэл зээлд ЗБДС-аас батлан даалт гаргана

<sup>37</sup> Хөдөө аж, ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд тоног төхөөрөмжийн үнийг 50 хувь хөнгөлнө

8.1.5 Цар тахалтай тэмцэх зорилгоор авч хэрэгжүүлсэн гадаад зээл, тусламж нийт 2,260.1 тэрбум төгрөг байна. Үүнд:

1. Төсвийн дэмжлэгийн хөтөлбөр нийт 658.9 сая ам.доллартой тэнцэх 1,978.0 тэрбум төгрөгийн зээл, 18.0 сая ам.доллар тэнцэх 53.9 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийн санхүүжилт авчээ.

АХБ 280.5 тэрбум (100.0 сая ам.доллар), ОУВС 279.6 тэрбум (99.5 сая ам.доллар), АДБХОБ 284.9 тэрбум (100.0 сая ам.доллар), Япон улс 687.8 тэрбум төгрөг (241.4 сая ам.доллар), АХБ-ны 171.1 тэрбум төгрөг (60.0 сая ам.доллар, ОУВС-ийн өргөтсөн хөтөлбөр), Дэлхийн банк 274.1 тэрбум төгрөг (100.2 сая ам.доллар, ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөр), Европын холбоо дөрвөн жилийн хугацаанд нийт 50.8 сая еврог буцалтгүй тусламжаар төсвийн дэмжлэг хэлбэрээр олгохоос гэрээний дагуу 53.9 тэрбум төгрөг (16.0 сая евро)

2. Хэрэгжиж байсан төслүүдээс зохицуулалт хийж нийт 71.2 тэрбум төгрөгийг зарцуулсан.

“Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 төсөл”-ийн 4.2 тэрбум, “Цахим эрүүл мэнд төсөл”-ийн 6.0 тэрбум, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн 42.6 тэрбум, “Боловсролын чанарын шинэчлэл төсөл” 14.3 тэрбум, “Экспортыг дэмжих төсөл”-ийн 4.1 тэрбум төгрөг.

3. Төслийн санхүүжилт хэлбэрээр нэмэлтээр авсан зээл, тусламж

**Зээл нийт 147.6 тэрбум төгрөг:** “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн 37.4 тэрбум, “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”-ийн 74.4 тэрбум, Дэлхийн банкны санхүүжилттэй “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн 7.3 тэрбум, Дэлхийн банкны санхүүжилттэй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн 28.5 тэрбум төгрөг.

**Тусламж нийт 9.3 тэрбум төгрөг:** АХБ-ны 6.7 тэрбум, Дэлхийн банкны Онцгой байдлын сангийн 2.6 тэрбум төгрөг.

#### Хүснэгт 27 Эдийн засгийн арга хэмжээ, эх үүсвэрээр /тэрбум төгрөг/

Эх үүсвэр	Нийт	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах	Иргэдийн орлогыг хамгаалах	Эдийн засгийг идэвхжүүлэх	Ажлын байрыг хадгалах
Улсын төсөв	1,396.4	110.1	853.2	211.7	221.4
Орон нутгийн төсөв	230.0	20.6			209.4
НДС	686.9				686.9
Гадаад зээл	2,196.9	216.6	86.5	1,818.5	75.3
Гадаад тусламж	63.2	9.3		53.9	
Бусад	243.0	15.1	214.4	13.5	
<b>Нийт дүн</b>	<b>4,816.4</b>	<b>371.7</b>	<b>1,154.1</b>	<b>2,097.6</b>	<b>1,193.0</b>

8.1.6 Нийт 2,260.1 тэрбум төгрөгийн төсвийн дэмжлэг, төслийн зээл, тусламжаас эдийн засгийг идэвхжүүлэхэд 1,701.4 тэрбум, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад 225.9 тэрбум, ажлын байр, орлогыг хамгаалахад 161.8 тэрбум нийт 2,089.1 тэрбум төгрөгийг зарцуулж, 171.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдэгдэлтэй байна.

### 8.1 Төсвийн орлогод үзүүлэх нөлөө

#### Хүснэгт 28 Татвар, НДШ-ийн хөнгөлөлт, чөлөөлөлт /тэрбум төгрөг/

Чөлөөлөлт, хөнгөлөлт	Ажлын байрыг хадгалах	ЭЗ-ийг идэвхжүүлэх	Дүн
<b>НДС-аас</b>	<b>647.0</b>		<b>647.0</b>
НДШ	619.1		619.1
НДШ-ийн торгууль, алданги	4.4		4.4
Сайн дурын даатгал	23.5		23.5
<b>Орон нутгийн төсвөөс</b>	<b>209.4</b>		<b>209.4</b>
ХХОАТ	209.4		209.4
<b>Улсын төсвөөс</b>	<b>221.2</b>	<b>52.0</b>	<b>273.2</b>
ААНОАТ	116.9		116.9
ААНОАТ-ын торгууль, алданги	49.0		49.0
Импортын барааны НӨАТ		35.3	35.3
Импортын ГАТ		16.7	16.7
Түрээсийн орлогод ногдуулах АТ	55.3		55.3
<b>Нийт дүн</b>	<b>1,077.6</b>	<b>52.0</b>	<b>1,129.6</b>

Короновируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ААН, иргэдийн ажлын байрыг хамгаалах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт улс, орон нутаг, НДС-ийн орлогод 1,129.6 тэрбум төгрөгийн нөлөө үзүүлсэн байна.

**8.2 Төсвийн зарлагад үзүүлэх нөлөө**

8.2.1 Цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээнд нийт 3,272.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнээс гадаад зээлийн эх үүсвэр 63.8 хувь буюу 2,089.1 тэрбум, улсын төсвөөс 34.3 хувь буюу 1,122.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт зардлын 98.1 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 29 Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулалт /тэрбум төгрөг/**

Зардлын төрөл	Ажлын байрыг хадгалах	Иргэдийн орлогыг хамгаалах	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах	ЭЗ-ийг идэвхжүүлэх	Нийт дүн
<b>Гадаад зээлээс</b>	<b>75.3</b>	<b>86.5</b>	<b>225.9</b>	<b>1,701.4</b>	<b>2,089.1</b>
Ажилгүйдлийн тэтгэмж	4.3				4.3
Сайн дурын даатгал	42.6				42.6
Хүнсний талон		0.7			0.7
Вакцинжуулалт			159.6		159.6
НДШ чөлөөлсөн	28.5				28.5
Хүүхдийн мөнгө		85.8			85.8
Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж			66.3		66.3
Төсвийн дутагдлыг санхүүжүүлэх				1,701.4	1,701.4
<b>НДС</b>	<b>39.9</b>				<b>39.9</b>
Ажилгүйдлийн тэтгэмж	39.9				39.9
<b>Орон нутгийн төсөв</b>			<b>20.6</b>		<b>20.6</b>
Ковид -19 зардал <sup>38</sup>			19.3		19.3
Тоног төхөөрөмж			0.5		0.5
Цалин, урамшуулал <sup>39</sup>			0.8		0.8
<b>Улсын төсөв</b>		<b>996.3</b>	<b>126.6</b>		<b>1,122.9</b>
Ковид-19 зардал			78.8		78.8
Ноосны урамшуулал		174.9			174.9
Тоног төхөөрөмж			24.6		24.6
Халамжийн тэтгэвэр		55.9			55.9
Цалин, урамшуулал			19.5		19.5
Хүнсний талон, хүүхэд хоол хүнс		19.3	3.7		23.0
Хүүхдийн мөнгө		746.2			746.2
<b>Нийт дүн</b>	<b>115.2</b>	<b>1,082.8</b>	<b>373.1</b>	<b>1,701.4</b>	<b>3,272.5</b>

8.2.2 Иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад гадаад зээлээс 225.9 тэрбум, улсын төсвөөс 126.6 тэрбум, орон нутгийн төсвөөс 20.6 тэрбум нийт 373.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

8.2.3 Мөн улсын төсвийн санхүүжилтийн 88.7 хувь буюу 996.3 тэрбум төгрөг иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн халамжийн зардал, 11.3 хувь буюу 126.6 тэрбум төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулсан байна.

<sup>38</sup> Эм, эмийн хэрэгсэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл;

<sup>39</sup> Халдварын голомтот бүсэд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнууд, төрийн холбогдох албан хаагчдад урамшуулал, илүү цаг.

## IX БҮЛЭГ. АУДИТЫН ОНЦЛОХ БУСАД АСУУДАЛ

9.1.1 Цахим шилжилтийг хурдасгах зарчмын хүрээнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас Нэгдсэн нэвтрэлтийн, Цахим төлбөрийн баримтын, Цахим тайлангийн, Татвар төлөгчийн бүртгэлийн, Бараа бүртгэлийн нэгдсэн, Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн, Төрийн албаны цалингийн нэгдсэн, Онцгой албан татварын тэмдгийн хяналтын, Санхүүгийн нэгдсэн мэдээллийн, Халамжийн нэгдсэн системүүдийг хөгжүүлж, нэвтрүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн байна.

9.1.2 Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын<sup>40</sup> дагуу төрөөс хариуцан төлөх айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан эрчим хүч, дулаан уур, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нийгмийн хариуцлагын хүрээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар нийт 464.0 тэрбум төгрөг зарцуулснаас тайлант онд хамаарах хөнгөлөлт, чөлөөлөлт 66.9 тэрбум төгрөг байна.

9.1.3 Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор тэтгэврийн 6.0 сая буюу түүнээс доош үнийн дүн бүхий зээлтэй нийт 228,574 иргэний 694.9 тэрбум төгрөгийг “Эрдэнэс монгол” ХХК-ийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар чөлөөлсөн байна.


9.1.4 Сүүлийн 3 жилийн төсвийн тухай хуулиар Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлага 25.0 тэрбум, Анод банкнаас авах авлага 10.0 тэрбум, Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон 20.6 тэрбум, нийт 55.6 тэрбум төгрөгийг эргэн төлүүлэхээр баталдаг боловч төлөлт хийгдээгүй байна.

9.1.5 Төлбөрийн чадвар буурсан нэр бүхий 2 банканд ЭМДС, НДС-ийн нийт 161.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршуулсан нь төлбөр барагдуулах, зарлагын гүйлгээ, гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтүүд хийгдээгүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байгаагаас сангийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах, хүүгийн орлого олох боломжийг бууруулж, байршуулсан мөнгөн хөрөнгөд эрсдэл үүсэж байна.

9.1.6 Дампуурсан Капитал банкны эрх хүлээн авагчаас төрийн байгууллагуудын авах авлагад үл хөдлөх хөрөнгийг авах саналыг ирүүлсэн нь хөрөнгийн үнэлгээ зах зээлийн үнээс хэт өндөр байх, хөрөнгө хэрэгцээ шаардлагагүй байх, хөрөнгийг худалдан борлуулах, хадгалах, хамгаалах нэмэлт зардал гарах сөрөг үр дагавартай байна.

## ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Зураг 4 Аудитын зөвлөмжийн биелэлт



Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 2 нийт 5 зөвлөмж хүргүүлсэн.

Өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлтийг Сангийн яам 2021 оны 13-1/1506 дугаар албан бичгээр 93.0 хувийн хэрэгжилттэй ирүүлсэн байна. Аудитаар зөвлөмжийн биелэлтийг 50.3 хувьтай үнэллээ.

<sup>40</sup> “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”

## ДҮГНЭЛТ

Монгол улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Тайлант оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 4,440.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 12.0 хувьтай тэнцэж, УИХ-аас тогтоосон хэмжээнээс хэтрээгүй байна.
2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Цар тахалтай холбоотойгоор төсөвт тодотгол хийхдээ нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хэмжээг 10.4 хувиар нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 12.5 хувиар бууруулан баталж орлого, зарлагын харьцааг хангаагүй байна.
3. Коронавируст халдвар (Ковид-19) Цар тахлын эсрэг эдийн засгийн “5.1 их наяд багц” арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын байрыг хадгалах татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд зориулсан 1,193.0 тэрбум төгрөг нь нэгдсэн төсвийн нийт орлогыг 13.0 хувиар бууруулж, улсын төсөв болон гадаад зээл, тусламжаас 3,272.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 23.5 хувийг, ДНБ-ий 8.8 хувийг тус тус эзэлж байна.
4. ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр 2017 оноос эхлэн хэрэгжиж 2,384.3 сая ам.долларын санхүүжилтийн эрх олгогдсоноос 1,329.2 сая ам.долларын дэмжлэг авч, 1,055.1 сая ам.долларын эх үүсвэрийг ашиглаагүй байна.
5. Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 10,444.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 438.7 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байгаа нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт өмнөх оноос 73.6 хувиар нэмэгдсэн, гадаад худалдааны эргэлт саарсан, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн тоо өссөнтэй холбоотой байна.
6. Засгийн газрын өр хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрээгүй боловч өмнөх оноос 15.3 хувиар нэмэгдсэн, гадаад зээлийн ашиглалт 3,368.4 тэрбум төгрөгөөс төсвийн дутагдлыг санхүүжүүлэхэд зориулж авсан хөтөлбөрийн зээл 1,978.0 тэрбум төгрөг буюу 58.7 хувийг эзэлж байна.
7. Гадаад зээл, үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн зөрүүнээс үүссэн алдагдал сүүлийн 5 жилд дунджаар 1,137.6 тэрбум, тайлант онд 1,355.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь ирээдүйд төлөх өрийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.
8. Төсвийн төсөл бэлтгэх удирдамжид хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулах нарийвчилсан зааврыг тусгаагүйгээс зарим хөтөлбөрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт оновчтой бус байна.
9. Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах зарим арга хэмжээ төсөвт тусгагдаж, тайлагнагдахгүй байгаа нь Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудтай нийцэхгүй байна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:**

Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 9,463.8 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 13,904.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.

Засгийн газрын амлалтын шинж чанартай эдийн засгийн арга хэмжээнүүдийн санхүүжүүлэх эх үүсвэр, зарцуулалтыг төсвийн бүрэлдэхүүнд оруулан төсвийн тухай хуулиар баталж байх;

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тогтолцоог боловсронгуй болгох зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг толилуулж байна.

**ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:**

- Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх, үе шаттайгаар хэрэгжилтийг хангаж, тайлагнах;
- Засгийн газраас хэрэгжүүлэх аливаа хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн шалгуурыг хэмжих нэгдсэн систем бий болгох ажлыг эрчимжүүлэх, зардлын үр ашгийг хянах тогтолцоог бүрдүүлэх, төсөв захирагчдын төсвийн сахилга батыг сайжруулах;
- Халамжийн хэт тэлэх бодлогыг хумих, төсвийн санхүүжилтээр ажлын байрыг бий болгох, эдийн засгийг сэргээх чиглэлд үр ашигтай зарцуулж, тайлагнаж байх;
- Засгийн газраас өрийн зохицуулалтын шинэчлэл хийх, бага хүүтэй, ханшийн эрсдэлгүй дотоод эх үүсвэрүүдийг ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэх;
- Дотоодын зах зээл дээр хүүгийн түвшин сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байгаа тул дотоодод засгийн газрын бонд гаргах замаар төсөвт ирэх ханшийн эрсдэлийг бууруулах, дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэмэгдүүлэх;

**САНГИЙН САЙД-д:**

- Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож, төсвийн төлөвлөлт, тодотголд тууштай баримтлах, орлого, зарлагын өсөлтийг уялдуулах;
- Өрийг дахин санхүүжүүлэх, нийгэм эдийн засагт зайлшгүй шаардлагатай төслийг санхүүжүүлэхээс бусад зорилгоор гадаад өрийг нэмэгдүүлэхгүй байх;
- ТЕЗ-дын харьяа байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, орлогын төлөвлөгөөгүй байгууллагуудад зарцуулах эрх олгохгүй байх, давсан орлогыг зарцуулах эрхийг жилд 2 удаа нээж санхүүжүүлэхээр тусгасан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

## Хавсралт 1 Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

	Нэгдсэн		Улсын		О Нулаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
ҮЗҮҮЛЭЛТ										
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,883.0	10,444.2	8,474.9	7,809.4	3,311.7	3,146.8	506.5	476.5	1,812.2	1,878.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	55.2	66.2	55.2	66.2	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	943.2	914.1	943.2	914.1	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,884.6	9,463.9	7,476.5	6,829.1	3,311.7	3,146.8	506.5	476.5	1,812.2	1,878.2
1. Татаарын орлого	8,905.9	8,511.7	6,095.9	5,690.2	1,287.6	1,235.5	506.5	476.5	1,411.7	1,477.7
1.1. Орлогын албан татвар	2,564.3	2,227.4	1,736.4	1,398.5	827.9	828.9	-	-	-	-
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	872.1	864.4	-	-	872.1	864.4	-	-	-	-
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,736.4	1,398.5	1,736.4	1,398.5	-	-	-	-	-	-
1.1.3. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	0.3	0.1	-	-	0.3	0.1	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-44.5	-35.6	-	0.0	-44.5	-35.6	-	-	-	-
1.3. Хөрөнгийн албан татвар	175.3	154.9	-	-	175.3	154.9	-	-	-	-
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,278.0	2,209.0	2,278.0	2,209.0	-	-	-	-	-	-
1.5. Онцгой албан татвар	734.9	776.9	734.9	776.9	-	-	-	-	-	-
1.6. Тусгай зориулалтын орлого	16.0	17.1	16.0	17.1	-	-	-	-	-	-
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	771.0	740.7	771.0	740.7	-	-	-	-	-	-
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	844.0	799.7	559.6	548.0	284.4	251.7	-	-	-	-
2. Татварын бус орлого	978.7	952.2	1,380.6	1,138.9	2,024.1	1,911.3	-	-	400.5	400.5
2.1. Нийтлэг татварын бус орлого	822.7	785.0	602.8	587.9	219.9	197.1	-	-	-	-
2.2. Хөрөнгийн орлого	1.5	1.2	-	-	1.5	1.2	-	-	-	-
2.3. Тусламжийн орлого	154.5	166.0	418.9	375.7	12.9	11.7	-	-	400.5	400.5
2.3. Төсөв хоорондын шилжүүлэг	-	-	358.9	175.3	1,789.8	1,701.3	-	-	-	-

## Хавсралт 2 Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

	ҮЗҮҮЛЭЛТ		Нэгдсэн		Улсын		О Нулаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,137.3</b>	<b>13,904.3</b>	<b>11,653.2</b>	<b>10,735.6</b>	<b>3,717.9</b>	<b>3,157.2</b>	<b>494.5</b>	<b>426.4</b>	<b>2,494.0</b>	<b>2,451.8</b>	<b>2,494.0</b>	<b>2,451.8</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>11,569.0</b>	<b>10,828.9</b>	<b>8,806.1</b>	<b>8,224.8</b>	<b>2,996.7</b>	<b>2,592.6</b>	<b>494.5</b>	<b>426.4</b>	<b>2,494.0</b>	<b>2,451.8</b>	<b>2,494.0</b>	<b>2,451.8</b>
1. Бараа, үйлчилгээний зардал	5,257.9	4,851.3	3,147.0	2,921.9	2,357.3	2,171.2	252	14.3	26.4	25.9	26.4	25.9
1.1. Цалин, хөлс	2,716.6	2,649.0	1,431.1	1,400.2	1,263.9	1,227.5	2.3	2.2	19.2	19.1	19.2	19.1
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-	-	130.2	122.7	165.1	156.6	0.3	0.3	2.5	2.4	2.5	2.4
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	2,541.3	2,202.3	1,585.7	1,399.0	928.3	787.1	22.6	11.8	4.7	4.4	4.7	4.4
<b>2. ХҮҮ</b>	<b>979.0</b>	<b>939.2</b>	<b>972.6</b>	<b>932.8</b>	<b>6.4</b>	<b>6.4</b>	-	-	-	-	-	-
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>5,332.1</b>	<b>5,038.4</b>	<b>4,686.5</b>	<b>4,370.1</b>	<b>633.0</b>	<b>415.0</b>	<b>469.3</b>	<b>412.1</b>	<b>2,467.6</b>	<b>2,425.9</b>	<b>2,467.6</b>	<b>2,425.9</b>
3.1. Татаас	458.2	375.0	633.6	564.7	173.7	168.6	50.3	41.1	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	4,873.9	4,663.4	4,052.9	3,805.4	459.3	246.4	419.0	371.0	2,467.6	2,425.9	2,467.6	2,425.9
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,514.0</b>	<b>3,034.3</b>	<b>2,828.5</b>	<b>2,487.5</b>	<b>685.5</b>	<b>546.8</b>	-	-	-	-	-	-
1. Барилга байгууламж	2,368.0	2,072.0	2,117.0	1,847.7	251.0	224.3	-	-	-	-	-	-
2. Их засвар	172.2	145.0	133.8	115.2	38.4	29.8	-	-	-	-	-	-
3. Хөрөнгийн бусад зардал	973.8	817.3	577.7	524.6	396.1	292.7	-	-	-	-	-	-
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>54.3</b>	<b>41.1</b>	<b>18.6</b>	<b>23.3</b>	<b>35.7</b>	<b>17.8</b>	-	-	-	-	-	-
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-170.2	-119.5	-205.9	-137.3	35.7	17.8	-	-	-	-	-	-
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	224.5	160.6	224.5	160.6	-	-	-	-	-	-	-	-

## Хавсралт 3 Нэгдсэн төсвийн тэнцэл

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,883.0	10,444.2	8,474.9	7,809.4	3,311.7	3,146.8	506.5	476.5	1,812.2	1,878.2
ТОГТВОРЖУУЛАГТЫН САН	55.2	66.2	55.2	66.2	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	943.2	914.1	943.2	914.1	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,884.6	9,463.9	7,476.5	6,829.1	3,311.7	3,146.8	506.5	476.5	1,812.2	1,878.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,137.3	13,904.3	11,653.2	10,735.6	3,717.9	3,157.2	494.5	426.4	2,494.0	2,451.8
ТЭНЦЭЛ -НИЙТ	-4,254.3	-3,460.1	-3,178.3	-2,926.2	-406.2	-10.4	12.0	50.1	-681.8	-573.6
ТЭНЦЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-5,252.7	-4,440.4	-4,176.7	-3,906.5	-406.2	-10.4	12.0	50.1	-681.8	-573.6
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	5,252.7	4,440.4	4,176.8	3,906.5	406.2	10.4	-12.0	-50.1	681.8	573.6
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	332.8	1,868.4	-669.8	1,355.3	332.8	-10.4	-12.0	-50.1	681.8	573.6
3. ЗГ-ын бонд	932.7	-249.4	932.7	-249.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1. Урт хугацаат	932.7	-249.4	932.7	-249.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1. Дотоод	932.7	-263.0	932.7	-263.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.1. Шинээр гаргах	1,195.7	-	1,195.7	-	-	-	-	-	-	-
3.1.1.2. Үндсэн төлбөр	-263.0	-263.0	-263.0	-263.0	-	-	-	-	-	-
3.1.2. Гадаад	0.0	13.6	0.0	13.6	-	-	-	-	-	-
3.1.2.1. Шинээр гаргах	2,861.0	1,692.6	2,861.0	1,692.6	-	-	-	-	-	-
3.1.2.2. Үндсэн төлбөр	-2,861.0	-1,679.0	-2,861.0	-1,679.0	-	-	-	-	-	-
3.2. Богино хугацаат	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.1. Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
4. ЗГ-ын зээл	3,311.3	2,661.4	3,311.3	2,661.4	-	-	-	-	-	-
4.1. Дотоод	240.6	-	240.6	-	-	-	-	-	-	-
4.1.2. Авлага	240.6	-	240.6	-	-	-	-	-	-	-
4.1.2.3. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.2. Гадаад	3,070.7	2,661.4	3,070.7	2,661.4	-	-	-	-	-	-
4.2.1. Төслийн зээл	748.7	683.3	748.7	683.3	-	-	-	-	-	-
4.2.1.1. Шинээр авах	1,472.9	1,374.4	1,472.9	1,374.4	-	-	-	-	-	-
4.2.1.2. Үндсэн төлбөр	-724.2	-691.1	-724.2	-691.1	-	-	-	-	-	-
4.2.2. Хөтөлбөр болон төслийн бус зээл	2,322.0	1,978.1	2,322.0	1,978.1	-	-	-	-	-	-
4.2.2.1. Шинээр авах	2,322.0	1,978.1	2,322.0	1,978.1	-	-	-	-	-	-
7. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-
8. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	149.7	138.8	149.7	138.8	-	-	-	-	-	-
9. Өмч хувьчлал	73.7	21.2	0.3	0.4	73.4	20.8	-	-	-	-
10. НДС-ийн арилжааны банкаас авах шилжүүлэг	452.5	-	452.5	-	-	-	-	-	-	-

**Хавсралт 4 Нэгдсэн төсвийн төлөвлөгөө ба гүйцэтгэл (ТЭЗ-аар) /тэрбум төгрөг/**

Улсын төсвийн ерөнхийлөн захирагч	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>11,634.9</b>	<b>10,712.2</b>	<b>-922.7</b>	<b>92.1</b>
Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	6.7	6.6	-0.1	98.5
Монгол улсын их хурлын дарга	47.3	44.4	-2.9	93.9
Монгол улсын үндсэн хуулийн цэцийн дарга	2.9	2.7	-0.2	93.1
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	4.7	3.5	-1.2	74.5
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	56.3	54.7	-1.6	97.2
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	1.6	1.5	-0.1	93.8
Улсын ерөнхий прокурор	43.7	41.6	-2.1	95.2
Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	4.7	4.6	-0.1	97.9
Монгол улсын ерөнхий аудитор	21.7	20.3	-1.4	93.5
Авлигатай тэмцэх газрын дарга	27.1	24.6	-2.5	90.8
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	4.6	4.3	-0.3	93.5
Төрийн албаны зөвлөлийн дарга	3.5	2.9	-0.6	82.9
Үндэсний статистикийн хорооны дарга	14.6	13.6	-1	93.2
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	38.1	37.3	-0.8	97.9
Монгол улсын ерөнхий сайд	160	150.1	-9.9	93.8
Монгол улсын шадар сайд	178.7	175.8	-2.9	98.4
Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	433	410.3	-22.7	94.8
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	157.8	132.5	-25.3	84
Гадаад харилцааны сайд	92.9	73.1	-19.8	78.7
Сангийн сайд	3,089.9	2,840.3	-249.6	91.9
Хууль зүй, дотоод хэргийн сайд	625.8	621.1	-4.7	99.2
Барилга, хот байгуулалтын сайд	203.3	161.4	-41.9	79.4
Батлан хамгаалахын сайд	287.7	268.9	-18.8	93.5
Боловсрол, шинжлэх ухааны сайд	1,717.1	1,553.0	-164.1	90.4
Соёлын сайд	180.8	129.5	-51.3	71.6
Зам, тээврийн хөгжлийн сайд	279.2	254	-25.2	91
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	36.2	34.6	-1.6	95.6
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2,379.9	2,229.8	-150.1	93.7
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	360.2	328.4	-31.7	91.2
Эрүүл мэндийн сайд	1,058.6	986.9	-71.7	93.2
Эрчим хүчний сайд	61.9	45.5	-16.5	73.5
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	54.4	54.4	-	100

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>3,717.9</b>	<b>3,157.2</b>	<b>-560.7</b>	<b>92.1</b>
Архангай	84.9	79.3	-5.6	93.4
Баян-Өлгий	96.5	88.4	-8.1	91.6
Баянхонгор	94.2	87.3	-6.9	92.7
Булган	71.7	64.1	-7.6	89.4
Говь-Алтай	72.8	64.8	-8.0	89.0
Говьсүмбэр	20.6	18.7	-1.9	90.8
Дархан-Уул	78.2	72.7	-5.5	93.0
Дорноговь	93.4	82.6	-10.8	88.4
Дорнод	78.1	71.9	-6.2	92.1
Дундговь	58.1	49.6	-8.5	85.4
Завхан	84.0	76.5	-7.5	91.1
Орхон	154.1	132.5	-21.6	86.0
Өвөрхангай	105.2	96.5	-8.7	91.7
Өмнөговь	236.1	200.7	-35.4	85.0
Сүхбаатар	73.2	66.0	-7.2	90.2
Сэлэнгэ	104.6	91.6	-13.0	87.6
Төв	105.2	92.5	-12.7	87.9
Увс	96.2	89.4	-6.8	92.9
Улаанбаатар	1,709.3	1,357.2	-352.1	79.4
Ховд	91.6	84.1	-7.5	91.8
Хөвсгөл	122.7	113.6	-9.1	92.6
Хэнтий	87.2	77.2	-10.0	88.5

## Хавсралт 5 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон макро эдийн засгийн үзүүлэлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
<b>Макро эдийн засгийн үзүүлэлт</b>					
ДНБ	23,942.9	27,876.3	32,411.2	37,280.8	36,958.6
ДНБ өсөлтийн хувь	1.2%	5.3%	7.2%	5.2%	-5.3%
Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	1.3%	6.4%	8.1%	5.2%	2.3%
Хадгаламжийн хүү	13.1%	12.9%	12.0%	11.3%	10.2%
Мөнгөний нийлүүлэлт M2	12,158.5	15,861.2	19,474.7	20,833.8	24,220.
Өсөлтийн хувь	21.0%	30.5%	22.8%	7.0%	16.3%
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	823.6	906.4	968.6	897.4	991.5
Өсөлтийн хувь	16.5%	10.1%	6.9%	-7.4%	10.5%
Экспорт (сая ам.доллар)	4,916.34	6,200.6	7,011.8	7,619.8	7,576.3
Өсөлтийн хувь	5.3%	26.1%	13.1%	8.7%	-0.6%
Импорт (сая ам.доллар)	3,358.14	4,337.3	5,875.	6,127.4	5,293.9
Өсөлтийн хувь	-11.6%	29.2%	35.5%	4.3%	-13.6%
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллар)	1,296.3	3,008.1	3,549.64	4,348.59	4,534.23
Өсөлтийн хувь	-2.0%	132.1%	18.0%	22.5%	4.3%
Ам.долларын тайлант үеийн эцсийн ханш	2,147.7	2,440.6	2,472.7	2,663.9	2,849.9
Өсөлтийн хувь	9.0%	13.6%	1.3%	7.7%	7.0%
<b>Төсвийн орлогын үзүүлэлт</b>					
Нийт орлого ба тусламжийн дүн	5,835.0	7,958.3	10,172.8	12,040.3	10,444.1
Өсөлтийн хувь	-2.5%	36.4%	27.8%	18.4%	-13.3%
Нийт орлого ба тусламжийн ДНБ-д эзлэх хувь	24.4%	28.5%	31.4%	32.3%	28.3%
Татварын орлого	4,951.0	6,315.1	8,227.8	9,813.2	8,511.6
Өсөлтийн хувь	-3.3%	27.6%	30.3%	19.3%	-13.3%
Татварын бус орлого	884.1	959.7	1,117.3	1,092.3	952.2
Өсөлтийн хувь	2.6%	8.6%	16.4%	-2.2%	-12.8%
Улсын төсвийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	48%	56%	59%	61%	59%
Орон нутгийн төсвийн орлого нийт орлогод эзлэх хувийн жин	27%	23%	21%	20%	24%
НДС-ийн төсвийн орлого нийт орлогод эзлэх хувийн жин	25%	20%	16%	17%	14%
ЭМДС-ийн орлого нийт орлогод эзлэх хувийн жин	0%	0%	3%	3%	4%
<b>Төсвийн зарлагын үзүүлэлт</b>					
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн*	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,904.2
Өсөлтийн хувь	33.0%	-5.0%	3.3%	25.2%	19.2%
Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь	40%	32%	29%	31%	38%
Урсгал зарлага	6,613.8	7,043.2	7,350.3	8,228.6	10,828.9
Өсөлтийн хувь	-2.5%	36.4%	27.8%	18.4%	-13.3%
Хөрөнгийн зардал	2,360.2	1,658.1	1,680.4	3,016.7	3,034.2
Өсөлтийн хувь	-2.5%	36.4%	27.8%	18.4%	-13.3%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	521.31	316.02	286.45	416.40	41.10
Өсөлтийн хувь	-2.5%	36.4%	27.8%	18.4%	-13.3%
Урсгал зарлагын нийт зарлагад эзлэх хувь	70%	78%	79%	71%	78%
Бараа, үйлчилгээний зардалын урсгал зардалд эзлэх хувь	47%	45%	45%	49%	45%
Хүүний төлбөрийн урсгал зардалд эзлэх хувь	15%	16%	14%	10%	9%
Татаас ба урсгал шилжүүлгийн урсгал зардалд эзлэх хувь	38%	39%	40%	41%	47%
Хөрөнгийн зардалын нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	25%	18%	18%	26%	22%
Эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт зарлагад эзлэх хувь	5.5%	3.5%	3.1%	3.6%	0.3%
<b>Засгийн газрын тэнцвэржүүлсэн тэнцэл</b>					
Төсвийн тэнцэл (тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон)	(3,660.29)	(1,742.46)	27.86	(756.19)	(4,440.51)
Өсөлтийн хувь	-2.5%	36.4%	27.8%	18.4%	-13.3%
Төсвийн тэнцэлийн ДНБ-д эзлэх хувь	-15.3%	-6.3%	0.1%	-2.0%	-12.0%
<b>Засгийн газрын өрийн үзүүлэлт</b>					
Засгийн газрын нийт өр	22,280.1	22,751.6	22,367.0	24,199.7	27,898.6
Өсөлтийн хувь	54.0%	2.1%	-1.7%	8.2%	15.3%
Засгийн газрын дотоод өр	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	1,136.6
Өсөлтийн хувь	63.7%	-40.3%	-54.8%	-10.6%	-18.8%
Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	18,865.6	20,728.1	24,851.4
Өсөлтийн хувь	56.8%	36.3%	11.9%	9.9%	19.9%
Засгийн газрын гадаад үнэт цаасны гадаад өрд эзлэх хувь	44%	46%	41%	38%	34%
Засгийн газрын гадаад зээлийн гадаад өрд эзлэх хувь	56%	54%	59%	62%	66%
Засгийн газрын өрийн баталгааны нийт өрд эзлэх хувь	15%	7%	5%	4%	4%
Барих-шилжүүлэх төрлийн концессийн нийт өрд эзлэх хувь	3%	3%	4%	4%	3%
Засгийн газрын өр (ӨҮЦ)	18,861.0	20,212.1	18,955.9	20,525.6	23,024.3
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	78.8%	72.5%	58.5%	55.1%	62.3%
Хуулиар тогтоосон өрийн хязгаар (Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ)	88.0%	85.0%	80.0%	75.0%	70.0%
Засгийн газрын нийт өрийн үйлчилгээний төлбөр	2,229.7	5,337.9	3,761.3	1,464.4	3,509.0
Төсвийн орлогод эзлэх хувь	38%	67%	37%	12%	33%
ДНБ-д эзлэх хувь	9%	20%	12%	4%	9%

**Товчилсон үгийн жагсаалт**

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБХОБ	Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
Ам.доллар	Америк доллар
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖАТ	Жирэмсэн амаржсаны тэтгэмж
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕС	Монгол улсын ерөнхий сайд
МУЕП	Монгол улсын ерөнхий прокурор
МУЕТГ	Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар
МУНТГ	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл
МУШС	Монгол улсын шадар сайд
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОАТ	Онцгой албан татвар
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУ	Олон улс
ОУВС	Олон улсын валютын сан
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
тн	Тонн
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их Хурал
УОК	Улсын онцгой комисс
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

ХНХЯ	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хүний хөгжлийн сан
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ШУ	Шинжлэх ухаан
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭТТ	Эрдэнэс таван толгой





